



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# 2012

---

ЖИЛИЙН ТАЙЛАН

# АРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	3
ӨМНӨТГӨЛ	4
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР	
Хүний эрх	6
Шүүхийн хараат бус байдал	9
Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь	11
Төрийн бус байгууллагуудын хөгжлийг дэмжих эрхзүйн орчин	12
Төрийн ил тод, хариуцлагатай байдал, иргэний нийгмийн оролцоо	13
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	23
Чөлөөт шударга сонгууль	24
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР	
Олборлох салбарын мэдээллийн ил тод байдал	29
Уул уурхайн орлогыг удирдах тогтолцоог бэхжүүлэх нь	31
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	34
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	37
Бизнесийн орчин	40
НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР	
Нийгмийн үйлчилгээний хүртээмж	42
Боловсролын үйлчилгээний хүртээмж	44
ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ	46
ПОРТАЛ САЙТ	47
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	48
ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	50
ДОРНО ДОРНО ХӨТӨЛБӨР	52
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	53
АЖИЛТНУУД	58

# ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж Ахуйн Нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ГХЯ	Гадаад Харилцааны Яам
ДӨЧИ	Дэлхийн Өрсөлдөх Чадварын Индекс
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
ИНБ	Иргэний Нийгмийн Байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЖДҮ	Жижиг Дунд Үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЛЭОС	Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮОНТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз
НДЭХ	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХҮХ	Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтэс
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ОҮИТБС	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачлага
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ТАН эвсэл	Төлсөн Авснаа Нийтэл
ТББ	Төрийн Бус Байгууллага
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
УИХ	Улсын Их Хурал
ХХИ	Хэрэглэгчийн Хүлээлтийн Индекс
ХЗЯ	Хууль Зүйн Яам
ХХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ЭМШУИС	Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль



# МНӨТГӨЛ

Нээлттэй Нийгэм Форум (ННФ) 2012 оны ээлжит тайлангаа Та бүхэнд толилууж байгаадаа таатай байна. Энэ он бидний хувьд олон жил идэвхи зүтгэл гарган ажилласан зарим ажлынхаа үр дүнг үзсэн, мөн улс орны хөгжлийн чухал сэдвийг хөндсөн шинэ төсөл санаачлагыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн жил байлаа.

2004 оноос эхлэн ННФ бусад төрийн бус байгууллагатай хамтран сонгуулийн мониторинг хийж, үр дүнг нь бодлого боловсруулагчид, олон нийтэд хүргэн, эрхзүйн шинэчлэлтэд хувь нэмэр оруулах нөлөөллийн цогц үйл ажиллагаа явуулсны үр дүнд УИХ-ын сонгуулийн шинэ хуульд сонгуулийг ил тод, шударга, хяналттай явуулахад чиглэсэн олон өөрчлөлт орлоо. Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний шинэчилсэн бүртгэлд үндэслэн улсын хэмжээнд нэгтгэн гаргах, нягтлан шалгах ажлыг Улсын бүртгэлийн газарт хариуцуулан хэсгийн хороод уг жагсаалтыг дур мэдэн хяналтгүйгээр өөрчилдөг явдлыг хориглов. Мөн шинэ хуулиар иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн өдрийн санал хураалтыг ажиглах боломжтой болсноор ННФ-ын дэмжлэгтэйгээр “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээнээс анх удаа сонгуулийн санал хураах байранд ажиглалт хийв. Сонгогчдын санал тоолох автоматжуулсан систем нэвтрүүлэх үйл явцад мөн бүрэн хэмжээний мониторинг хийж дүгнэлт гаргалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж батлуулсан шүүхийн тухай багц хуулийн “Шүүхийн иргэний төлөөлөгчийн тухай ” хуулийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран иргэд шүүх үйл ажиллагаанд оролцоход зориулсан гарын авлага, мэдээллийн багц материал боловсруулж эхлээд байна. Түүнчлэн Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран шүүхийг олон нийтэд илүү нээлттэй болгоход чиглүүлэх шүүхийг сурвалжлах талаар сэтгүүлчдэд зориулан сургалт, хэлэлцүүлгүүд зохион байгууллаа. Мөн эрүүгийн эрхзүйн шинэтгэлийн багц хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлж салбарын мэргэжилтэн, судлаачдыг хуулийн төсөл боловсруулах болон хөндлөнгийн шүүмж гаргах, хэлэлцүүлэх үйл явцад үр нөлөөтэй оролцуулах боломж нөхцлөөр хангалаа. ННФ 2012 оноос эхлэн ХЭҮК-той хамтран дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид, хүний эрхийн зүтгэлтнүүдийг урьж олон нийтэд зориулсан хүний эрхийн цуврал лекц зохион байгуулж ирсэн нь хүний эрхийн

талаарх ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлэхэд ач холбогдолтой үйл ажиллагаа болж төлөвлөө.

Найм дахь жилдээ хэрэгжүүлж буй “Төрийн бус байгууллагуудын мониторингийн тэтгэлэгт хөтөлбөр”-т 2012 онд хот, хөдөөгийн 31 байгууллага шалгарч төсөв, төрийн хариуцлага ил тод байдал, хүний эрх ба уул уурхай зэрэг таван чиглэлээр мониторинг хийж байна.

Олборлох салбарын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч “Төлсөн авснаа нийтэл” төрийн бус байгууллагуудын эвсэлтэй хамтран Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС)-ын хүрээнд 2006 оноос хойш гарсан үндэсний бүх тайланд дүн шинжилгээ хийж, салбарын төлбөрийн талаарх мэдээллийг цуглуулах, хадгалах, боловсруулах, олон нийтэд хүргэхтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлын зөвлөмж гаргасныг ОУИТБС-ын ажлын алба анхааралдаа авч шийдвэрлэхээр ажиллаж байна. Олборлох салбарын бодлогыг хянах иргэний нийгмийн чадавхийг нэмэгдүүлэхэд мөн багагүй анхаарч бусад орны туршлага судлах, Монголын иргэний нийгмийн туршлагыг бусад оронд түгээх сургалт, семинарт эвслийн гишүүдийг оролцоход дэмжлэг үзүүлэв.

ННФ “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ, “Ил тод байдлын сан” ТББ-тай хамтран 2012 онд шинээр “Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах загвар стандарт”-ыг боловсруулж Ховд аймгийн хоёр сум, Улаанбаатар хот болон Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус туршиж хэрэгжүүлээ. Мөн энэ онд шинээр эхлүүлсэн “Монгол Улсын эрчим хүчний засаглал” санаачлагын хүрээнд энэ салбарын засаглалын үнэлгээ анх удаа хийгдэж цаашид иргэний нийгмийн сүлжээ байгуулан олон улсын түншүүдтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Уул уурхайгаас орох орлогын менежментийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор нөхөгдөшгүй баялгийг зөв зохистой, үр өгөөжтэй зарцуулахаас улс орны ирээдүйн хөгжил хэрхэн хамаарахыг төсөөлсөн “2021 оны Монголын зураглал” боловсруулж олон нийтэд хүргэв.

Нийгэм, боловсролын бодлогын хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн хүүхдүүдэд бусдын адил чанартай сайн боловсрол олгох, өвөрмөц хэрэгцээнд нь нийцсэн сурах орчин нөхцөл бүрдүүлэх чиглэлээр нөлөөллийн ажил явуулсны үр дүнд уг асуудал бодлогын түвшинд хэлэлцэгдэх чухал сэдэв болов.

Бидний санаачилж хийж буй, мөн хэрэгжүүлэхээр зорьж буй үйл ажиллагааны тайлантай танилцан санал, бодлоо хуваалцах аваас бид гүнээ талархан хүлээн авах болно.

*Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
П. Эрдэнэжаргал*

# З

## АСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

### ХҮНИЙ ЭРХ

#### ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

НҮБ-ын хүний эрхийн механизмыг ашиглан Монголын хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр ТББ-уудын өмнөх онуудад олсон амжилтыг бататгах, энэ чиглэлээр чадавхийг нь бэхжүүлэхэд ННФ ихээхэн анхаарал хандуулж ажиллалаа.

НҮБ-ын Хүний эрхийн хороо Монгол Улсын Иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийг хэлэлцээд 2011 онд Засгийн газарт хүргүүлсэн Дүгнэлт зөвлөмжид гурван зөвлөмжийг тусгайлан авч үзэж, нэн тэргүүнд биелүүлэхийг үүрэг болгосон бөгөөд үүнд хүний эрхийн ТББ-уудаас сүүдрийн илтгэл илгээж, АНУ-ын Нью Йорк хотноо болсон тайлан

хэлэлцэх уулзалтад төлөөлөө биечлэн оролцуулсан явдал чухал нөлөө үзүүлсэн юм. НҮБ-ын Хүний эрхийн хороо нэн тэргүүнд хэрэгжүүлэхээр даалгасан зөвлөмжүүдийн хэрэгжилтдээ үнэлгээ хийлгэхээр өөрийн тусгай элчийг энэ онд манай улсад ажиллуулав.

ННФ нь хүний эрхийн хорооны тусгай элч бөгөөд тус хорооны гишүүн Кристер Телины ажлын айлчлалыг Хүний эрх хөгжил төв, Глоб Интернэшнл ТББ-уудтай хамтран зохион байгууллаа. Тус айлчлалын үеэр НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Засгийн газар болон иргэний нийгмийн төлөөлөгчидтэй

тусгайлсан уулзалт хийж, хэвлэлийн хурал зохион байгуулсан юм.

Монголын ТББ-ууд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт оролцох явцдаа НҮБ-ын хүний эрхийн механизмыг ашиглан хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах арвин туршлагыг хуримтлууллаа. Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь тасралтгүй үйл явц, бүх талуудын оролцоог хангахад чиглэдэг, НҮБ-ын бүх гишүүн улсад хамаатай зэрэг олон давуу талтай механизм билээ. Тиймээс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 онд Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх явцад иргэний нийгмийн байгууллагын

үүрэг оролцоо чухал болохыг ННФ онцгойлон анхаарч ирсэн болно. 2012 оны 12-р сард УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, ХЭҮК, ГХЯ хамтран НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч буй арга хэмжээ болон төлөвлөж байгаа ажлын талаар олон нийтэд мэдээлэх нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулав. Тус зөвлөгөөнд ННФ оролцож, Хүний эрхийн ТББ-уудын форумыг төлөөлөн мэдээлэл хийж, санал зөвлөмж хүргүүлээд байна. Энэхүү зөвлөгөөний үр дүнд зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, үндэсний хэмжээний зөвлөлдөх үйл явцыг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газар санаачлага гарган ажиллахаар боллоо.

ННФ нь Хүний эрхийн ойлголтыг Монгол Улсад

түгээн дэлгэрүүлэх, онолын түвшинд хөгжүүлэх, хүний эрхийн мэдрэмж, хандлагыг бүхий л салбарт гүнзгийрүүлэхэд хувь нэмэр болох үүднээс ХЭҮК-той хамтран 2012 оноос хүний эрхийн цуврал лекц зохион байгуулж байна. Хүний эрхийн чиглэлээр өндөр мэргэшсэн, энэ сэдвээр судалгаа шинжилгээ хийдэг дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид илтгэл тавьж оролцдог нь энэхүү цуврал лекц олны сонирхлыг татах чухал хүчин зүйл болж байна. Энэ онд дараах сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүлээд байна. Үүнд:

- УИХ-ын гишүүн, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга Х. Тэмүүжин **“Парламентын хяналт ба Хүний эрх”**;

- АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийн Хүний эрхийн академик хөтөлбөрийн Захирал Минди Жейн Роүзмен **“Эхчүүд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд хүний эрхийн үүднээс хандах нь”**;

- ХЭҮК-ын дарга, хууль зүйн ухааны доктор, профессор Ж.Бямбадорж **“Хүний эрх ба Монгол Улсын Үндсэн хууль”**;

“МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээний ерөнхий зохицуулагч, “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвслийн зөвлөх Т. Ундарьяа **“Хүний эрхэм чанар, төр ба хүмүүнлэг нийгэм”**;

#### Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт 2011-2012 онд хэрэгжүүлэхийг даалгасан зөвлөмж:

1. Гишүүн улс нь комиссын гишүүдийг томилох үйл явцыг хянан үзэх, хангалттай хүний нөөц, төсөвтэй болгох замаар Хүний эрхийн үндэсний комиссын бие даасан байдлыг хангах.
2. Гишүүн улс нь 2008 оны 7 сард зарласан онц байдлын үеэр хүний эрхийг зөрчсөн хэрэг, гомдол нэг бүрийг нягтлан шалгах, энэ хүрээнд хохирогчдын гэр бүлийн гишүүдэд олгосон нөхөн олговрын асуудлыг ч хамруулан авч үзэх. Мөн хэрэгт холбогдогсдыг мөрдөн шалгах, буруутай нь тогтоогдвол зохих шийтгэлийг ногдуулах, хохирогчдод хангалттай нөхөн олговор олгоход анхаарах.
3. Гишүүн улс шүүх эрх мэдлийн тогтолцоо нь Пактын үзэл санаа, зарчимд нийцэж буй эсэх, бүтэц, механизм нь шүүхийн ил тод, хараат бус байдлыг хангахад чиглэгдэж байгаа эсэхийг дүгнэж үзсэний үндсэн дээр шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр батлах. Түүнчлэн энэхүү шүүхийн шинэтгэлийн баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл явцад олон талын оролцоо, тэр дундаа мэргэжлийн бүлгүүд, иргэний нийгмийн оролцоог хангах. Шүүгчдийн холбогдсон авилгын хэрэг нэг бүрийг ул суурьтай мөрдөн шалгах.

- “Хүний эрх - Хөгжил” төвийн тэргүүн Г. Уранцоож **“Хөгжих эрх”**;
- ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор П. Оюунчимэг **“Эрүүгийн эрхзүйд хүний эрх”** сэдвээр тус тус илтгэл тавилаа.

Эдгээр илтгэлийн видео бичлэгийг ННФ-ын вэб сайтад байрлуулж, олон нийтэд хүртээмжтэй болголоо (Хүний эрхий

цуврал илтгэлийг [www.forum.mn](http://www.forum.mn) хаягаар үзнэ үү).

ННФ нь Хүний эрхийн үндэсний механизмыг бэхжүүлэх хүрээнд ХЭҮК-той хамтран ажиллахыг эрхэмлэдэг юм. ХЭҮК-ын дэргэдэх ТББ-ын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөлийн гишүүн байгууллагын хувьд тус зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох замаар үйл ажиллагааг нь дэмжиж ирсэн.



## ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

2011 оноос эрчимжсэн шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хувьд 2012 он чухал үйл явдал тохиосон онцлогтой жил байлаа. Энэ нь Шүүхийн тухай хууль хэмээх ганц хуулийн хүрээнд хэрэгжиж ирсэн шүүх эрх мэдэл таван багц хуулиар зохицуулагдах болсон явдал юм. УИХ-аас баталсан эдгээр багц хууль нь хэд хэдэн шинэ бүтэц, механизм бий болгож байгаа тул хууль хэрэгжих бэлтгэлийг хангах зорилгоор 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр болов.

ННФ нь “Шүүхийн иргэний төлөөлөгчийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэгт ажиллаж байгаа бөгөөд энэхүү шинэ механизмыг амжилттай хэрэгжүүлэхэд шүүхийн захиргааны зүгээс олон дэд зохицуулалт бий болгох, иргэдэд хандсан таниулах, сурталчлах ажлыг эрчимтэй хийх шаардлага тулгарч байгаа юм. Хуулийн гол үзэл санаа нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд иргэдийн үр нөлөөтэй оролцоог хангахад оршиж байгаа тул шүүн таслах үйл явцад иргэд мэдээлэлтэй оролцох явдал нэн чухал билээ. Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны

багц материал боловсруулах ажлыг 2012 онд эхлүүлээд байна.

Шүүхийн тухай багц хууль батлагдаж, шүүхийн шинэтгэл хууль эрхзүйн хувьд амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч олон нийтийн дунд шинэтгэлийн үзэл санааг таниулах сурталчилгаа учир дутагдалтай байна. Иймд 2012 оны 4 дүгээр сард ННФ-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран “Шүүхийн шинэтгэл-Хэвлэл мэдээлэл” төслийн хүрээнд “Шүүхийг сурвалжлах нь” сургалт зохион байгууллаа. Сургалтад өдөр тутмын сонин, цахим мэдээллийн сайт, телевиз зэрэг 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид болон Улсын дээд шүүх, Нийслэлийн шүүхийн олон нийттэй харилцах албаны ажилтнууд оролцож хүний эрхийн үндсэн ухагдахуун, тэр дундаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн тухай ойлголттой гүнзгий танилцсан болно.

*Гэрэл зургийг Б. Бямба-Очир, Ухуулагчид иргэдийг уулзалтад урьж буй нь, Дархан-Уул аймаг 2012 оны 6 дугаар сарын 8.*

Сургалтыг Польш улсын Варшав хотноо байрлах Олон улсын Хельсинки хорооны хүний эрхийн зөвлөх, сургагч багш Доминика Бихавска, Мариа Эйрхарт нар удирдан явууллаа. Дээр дурдсан сургагч багш нар нь шүүхийн үйл ажиллагаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилтэд мониторинг хийх чиглэлээр Зүүн Европ, Төв Азийн олон оронд сургалт, судалгаа хийж байсан туршлагатай мэргэжилтнүүд юм.

Сэтгүүлчид сургалтын үеэр хүний эрхийн стандартуудтай танилцахын сацуу шүүх хуралдааныг дуурайн тоглож өөрсдийн биеэр шүүгч, улсын яллагч, өмгөөлөгч, шүүгдэгч, хохирогч, гэрчийн байр сууринаас шүүхийн процессыг таньж мэдэх боломжоор хангагдсан нь уламжлалт сургалтаас онцлогтой болов. Сургалтын төгсгөлд сэтгүүлчдийн дунд шүүхийн тухай шилдэг нийтлэл шалгаруулах уралдаан зарлаж 5 нийтлэлийг шалгаруулж урамшуулав.

Шүүх эрх мэдлийн хүрээний шинэтгэл нь шүүхийн тухай багц хууль батлагдсанаар бүрэн хэрэгжихгүй бөгөөд шүүхэд хэрэглэгдэх бусад хуулийн шинэчлэлт, шинэтгэлийн нэг томоохон баталгаа болох юм. Иймээс Монгол Улсын Засгийн газраас шүүхийн шинэтгэлийн дараагийн шат болгож эрүүгийн эрхзүйн шинэтгэлийг эхлүүллээ. Шинэтгэлийн хүрээнд шүүхийн өмнөх болон дараах шатны ажиллагааг зохицуулах процессын шинжтэй хуулиуд, эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад оролцогч талуудын эрх үүргийг зохицуулж, баталгаажуулсан тусгайлсан хуулиуд хамрагдаж байна. Түүний зэрэгцээ эрүүгийн гэмт хэргийн тухай ойлголтыг зарчмын хувьд эргэн харж Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах ажил ч мөн эхэллээ.

2012 онд ННФ дараах хуулийн төсөл боловсруулах ажлыг зөвлөх багийн тусламжтайгаар хийж гүйцэтгэн Хууль зүйн яамны Эрхзүйн шинэтгэлийн газарт хүлээлгэн өгөв. Үүнд:

- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн шинэчилсэн найруулга
- Цагдаагийн байгууллагын тухай хууль
- Цагдаагийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай хууль
- Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль
- Мөрдөх албаны тухай хууль зэрэг орно.

Хууль зүйн яам тэргүүн зорилтоо эрүүгийн эрхзүйн шинэтгэл хэмээн зарлаж, эхний байдлаар боловсруулсан хуулийн төслүүдийг олон нийтийн дунд хэлэлцүүлэх ажил эхлүүлээд байна. Дээр дурдсан хуулиас гадна Гэрч хохирогчийн эрхийг хамгаалах тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай, Маршалын албаны тухай зэрэг хуулийн төслийг шинээр боловсруулж байна. ННФ Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл боловсруулах ажилд техникийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.

Энэхүү томоохон эрхзүйн шинэтгэлийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд аль болох олон талын оролцоог хангах, ялангуяа эрдэмтэн судлаачдын санал бодлыг тусгах нь нэн чухал гэж үзэж нийт 10 гаруй хуулийн төсөлд эрүүгийн эрхзүйн чиглэлээр онол, практикийн өндөр мэдлэг туршлагатай дотоодын зөвлөхүүдийн санал шүүмжийг авах ажлыг эхлүүлээд байна.

ННФ-ын 2008 оноос эхлэн хэрэгжүүлж буй Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн онцлог нь дотоодын эрдэмтэн судлаачдын оюун чадавхийг дайчлан, тэдний өргөн оролцоог хангаж ирсэн явдал юм. Эрүүгийн эрхзүйн онцлог нь тухайн улсын нийгэм, соёл, уламжлалын үнэт зүйлстэй нягт уялдаатай зохицуулагддаг явдал бөгөөд энэ ч утгаараа үндэсний эрдэмтэн судлаачдын үзэл бодол үнэ цэнэтэй байх учиртай.

## НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ НЬ

ННФ-ын санаачлага, хүний эрх болон байгаль орчны ТББ-уудын идэвхи, зүтгэлээр 2000 оноос эхлэн нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах туршлага бий болж, нийгэмд тулгарч буй олон асуудлаар нийтийн эрх ашиг, иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалахад тодорхой үр дүн гарлаа. Гэвч нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалахад нэлээдгүй хүндрэл бэрхшээл тулгардаг ба түүний нэг нь эрхзүйн таатай орчинг бүрдүүлэх асуудал юм.

Энэ хүрээнд “Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь” сэдэвт онол практикийн хурлыг Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран 2012 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдөр Их Тэнгэр цогцолборт зохион байгууллаа. Энэ хурлаар нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалахад тулгарч буй хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар хууль, шүүх, төрийн болон төрийн бус байгууллагууд, өмгөөлөгчид, хуулийн сургуулийн төлөөлөл санал солилцон цаашид нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааг Монгол Улсад түгээн дэлгэрүүлэхэд таатай эрхзүйн орчинг

бүрдүүлэхэд шаардлагатай холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар тодорхой санал зөвлөмж гаргалаа.

Олон улсын туршлага, чиг хандлагатай танилцах үүднээс Харвардын Хуулийн сургуулийн Хүний эрхийн хөтөлбөрийн захирал Минди Жейн Роүзмен, Нийтийн эрх ашгийн хуулийн дэлхийн сүлжээний Бээжин дэх салбарын захирал Роберт Прехт нарыг хуралд урьж оролцуулсан нь чухал ач холбогдолтой боллоо.

Онол практикийн бага хурлын дараа ННФ төрийн бус байгууллагуудын идэвхи санаачлагыг дэмжиж нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах талаар ажиллах сонирхолтой төрийн бус байгууллагуудын дунд тэтгэлэгт уралдаан зарласан юм. Одоогоор нийтийн эзэмшлийн газрын маргаан, ахуйн хог хаягдлын менежмент, байгаль орчны хууль тогтоомжийн асуудлаар гурван байгууллага нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэх төсөл хэрэгжүүлж байна.



“Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь” сэдэвт онол практикийн бага хурал. 2012 оны 4 дүгээр сарын 26, Их тэнгэр цогцолбор.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал тулгамдсан хэвээр байна. ННФ нь ашгийн бус үйл ажиллагааны эрхзүйн зохицуулалтын талаар ТББ-ын төлөөлөл болон судлаачид оролцсон хоёр өдрийн санал солилцох уулзалт зохион байгуулсан нь ТББ-ууд ашгийн бус салбарын зохицуулалтын талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх, байр сууриа нэгтгэхэд чухал ач холбогдолтой боллоо. Түүнчлэн төрийн болон төрийн бус байгууллагуудын зөвлөлдөх цуврал уулзалт зохион байгуулж нийгэмд тустай үйл ажиллагааг зохицуулах талаар Ерөнхийлөгчийн Тамгын газраас гаргаж буй санаачлага, төрийн бус байгууллагын эрхзүйн орчныг цаашид боловсронгуй болгох шаардлага, үйл явцын талаар Хууль Зүйн Яамнаас баримталж буй бодлогын талаар иргэний нийгмийн төлөөлөл санал солилцож, байр сууриа илэрхийллээ. Ашгийн бус үйл ажиллагааны Европ дахь төвийн мэргэжилтнүүд төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзаж олон улсын сайн туршлага, эрхзүйн зохицуулалтын талаар мэдээлэл хуваалцлаа.

*Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход Хууль Зүйн Яамнаас баримталж буй бодлогын талаар иргэний нийгмийн төлөөлөл санал солилцож байр сууриа илэрхийллээ. 2012 оны 12 дугаар сар, ННФ-ын хурлын танхимд.*

## ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО



### ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ, МОНИТОРИНГ

ННФ төрийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэх, улмаар тэдгээр байгууллагын хөндлөнгийн хяналт тавих чадавхийг дээшлүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсаар ирлээ. 2012 онд зарласан тэтгэлэгт хөтөлбөрт нийт 31 төрийн бус байгууллага шалгарч (Улаанбаатар хотод 14, хөдөө орон нутагт 17) төсөв, төрийн болон нийгмийн үйлчилгээ, төрийн хариуцлага, ил тод байдал, хүний эрхийн болон уул уурхай, газрын тос, байгалийн хийн таван салбар чиглэлээр төр засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийх цогц үйл ажиллагаа явуулж байна.

## 2012 оны мониторингийн хөтөлбөрт шалгарсан ТББ-ын жагсаалт

Байгууллагын нэр	Төслийн зорилго
<b>Төсвийн зарцуулалтад хяналт тавих чиглэлээр</b>	
1 Ховд аймгийн ажил олгогч эздийн Бадрал холбоо ТББ (Ховд аймаг)	Монгол Улсын төсвөөс жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин олгож буй санхүүжилтийн орон нутаг дахь тогтолцоо, хэрэгжилтэд мониторинг хийх
2 Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан ТББ (Улаанбаатар хот)	Улсын төсвийн хөрөнгөөр Туул голын эхийг ойжуулсан үйл ажиллагаанд мониторинг хийх
3 Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Өмнөговь аймаг дахь салбар	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс зээл олгох, зарцуулах, хяналт тавих, зээлийг эргэн төлүүлэх, тайлагнахтай холбоотой сумын ИТХ-ын эрх үүргийн хэрэгжилт, сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт үнэлгээ хийж зөвлөмж боловсруулах
4 Буйр нуур Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ (Дорнод аймаг)	Иргэдийн сайн дурын нөхөрлөл байгуулах замаар Байгалийн нөөц ашиглах хуулийн хэрэгжилтийг хянах
5 Хуулийн хэрэгжилтийг хянах иргэдийн холбоо ТББ (Дорнод аймаг)	Дорнод аймаг дахь орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, эрхзүйн зохицуулалтад хяналт тавих, цаашид авах арга хэмжээг тодорхойлох
6 Хүнсний тусгаар байдлын төлөө хүмүүсийн эвсэл ТББ (Улаанбаатар хот)	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” 0115-MON (SF) төслийн зарцуулалт, зээлийн гэрээний нөхцөл, аж ахуй эрхлэгчдийн аж ахуйд чанарын ямар өөрчлөлт гарч буйг баримтаар гаргах, орон нутагт тогтвортой хөгжил бий болоход хэр нөлөөлж байгаад дүгнэлт гаргах
7 Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын холбоо (Говь-Алтай аймаг)	Говь-Алтай аймгийн сургууль цэцэрлэгийн байгууллагуудад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явц, гүйцэтгэсэн ажлын үр дүн, чанар, төслийн хэрэгжилтийг судалж, хяналт үнэлгээ хийх
8 Хорол тооно нийгэмлэгийн Дорнод аймаг дахь салбар	“Эрүүл хүүхэд-Монголын ирээдүй” аяны хэрэгжилтийн байдалд мониторинг хийх
9 Татварт иргэний хяналт (Улаанбаатар хот)	Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх
10 Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор төв (Улаанбаатар хот)	Улаанбаатар хот, Дундговь, Баянхонгор, Увс аймаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилт болон хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийсэн бүтээгдэхүүнийг нэгдсэн зах зээлд гаргах замаар бизнесийн чанарыг сайжруулж ажлын байрыг нэмэгдүүлэх” хөтөлбөр боловсруулах замаар бодлого, түүний хэрэгжилтэд нөлөөлөх
12 Баянхонгор аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн салбар зөвлөл	
13 Увс аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн салбар зөвлөл	

Байгууллагын нэр	Төслийн зорилго
<b>Төрийн хариуцлага, ил тод байдлын чиглэлээр</b>	
14 Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Төв аймаг дахь салбар	Иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах талаар баталгаажуулан зохицуулсан хууль, тогтоомжийг аймаг, сум, багийн түвшинд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд мониторинг хийх
15 Төв аймгийн Иргэний нийгмийн сүлжээ	Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, засаг захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт болон үр дүнд хяналт тавих
16 Захиргааны шинэ санаачлага ТББ (Улаанбаатар хот)	“Цэвэр агаар сан” -гийн үйл ажиллагаа, санхүүжилтийн зарцуулалтын ил тод байдал, ашиг сонирхлын зөрчилд мониторинг хийж, зөвлөмж боловсруулах
<b>Төрийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр</b>	
17 Дундговь-Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ ТББ	Дундговь аймгийн амбулатори, эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн ажил үйлчилгээний чанар хүртээмж, төлбөрийн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах гарцыг бий болгоход нөлөөлөх
18 Гэр бүлийн эрүүл мэндийн сайн сайхны төлөө ТББ (Улаанбаатар хот)	Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын байгууллагуудад эмчилгээ, эм, эрүүл ахуйн чиглэлээр хяналт тавьдаг улсын байцаагчдын гаргасан дүгнэлт зөвлөмжийн үр нөлөөг судалж, цаашид сайжруулах талаар санал зөвлөмж гаргах
19 Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн нийгэмлэг ТББ (Улаанбаатар хот)	Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний шошгожилтын байдал түүнтэй холбогдох хууль эрхзүйн баримт бичиг, стандарт, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хууль эрхзүйн зохицуулалтад бодит зөвлөмж гаргах
20 Түгээмэл хөгжил ТББ (Улаанбаатар хот)	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зориулалтаар хийгдэж буй төсвийн зарцуулалтад мониторинг хийх
21 Хөгжлийн хэлхээ төв ТББ (Улаанбаатар хот)	Нийгмийн эмзэг бүлгийнхнийг өдрийн үйлчилгээнд хамруулж байгаа байдал, тэдэнд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, Нийгмийн халамжийн тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалт, стандартуудын хэрэгжилтэд мониторинг хийж зөвлөмж боловсруулах
22 Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөнийн Ховд аймаг дахь салбар	Нийгмийн халамжийн үйлчилгээний Баруун бүсийн нөхөн сэргээх төвийн үйл ажиллагаанд мониторинг хийх
23 Хатансэмбэрүү ТББ (Завхан аймаг)	Газар олгох ажиллагааны анхан шатны нэгж дэх хүнд суртал, авилга, гажуудлыг бодитойгоор илрүүлэн баримтжуулж, энэ харилцаан дахь гүйцэтгэх шатны төрийн албан хаагчийн хариуцлагыг өндөржүүлэх талаар эрх бүхий субъектэд санал зөвлөмж хүргүүлэх
24 Баянхонгор аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн холбоо	Ерөнхий боловсролын сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэх тухай заалтын хэрэгжилт, өнөөгийн байдалд үнэлгээ өгч цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөөлөх

Уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт

25	Ногоон ертөнц байгаль орчин ТББ (Улаанбаатар хот)	“Ашигт малтмалын тухай хууль”-д заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч /лиценз эзэмшигч/-ийн үүргийн биелэлтэд мониторинг хийх
26	Их Бага Баяншарга сан ТББ (Улаанбаатар хот)	Цацраг идэвхит ашигт малтмалын мэдээлэл олон нийтэд хэрхэн хүрч байдаг, холбогдох эрхзүйн зохицуулалтад мониторинг хийх
27	Цөмийн цацрагийг хянах Монголын нийгэмлэг ТББ (Дорнод аймаг)	Дорнод аймагт уран олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч буй сөрөг нөлөөллийн цар хүрээг орон нутгийн иргэдийн оролцоо, мэргэжлийн байгууллагууд, баримт мэдээлэлд тулгуурлан тодорхойлж, зөвлөмж боловсруулах

Хүний эрхийн чиглэлээр

28	Монголын Чөлөөт Нийгмийн ажилтны төв (Дорнод аймаг)	Орон нутаг дахь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжид зохих хууль, стандартын дагуу мониторинг хийж энэхүү үйлчилгээг сайжруулахад чухал шаардлагатай төсвийг олон нийтийн оролцоо, хяналттайгаар тусгуулахад нөлөөлөх
29	Монголын худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооллын төв холбоо (Улаанбаатар хот)	Нийслэл хот болон Дундговь аймагт иргэдийн хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн байдал, учир шалтгаанд дүн шинжилгээ хийж хөдөлмөрлөх эрхийг тэгш хангахад чиглэсэн үйл ажиллагааг хуулийн хүрээнд ил тодоор зохистой явуулахад дэмжлэг үзүүлэх
30	Эмэгтэй Удирдагч сан (Улаанбаатар хот)	Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 3 дахь үе шат болох 2009-2012 оны үйл ажиллагаанд мониторинг хийх
31	Онол арга ТББ (Улаанбаатар хот)	Иргэний бүртгэл мэдээллийн систем дэх хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын бодлогод сөргөөр нөлөөлж буй байдалд дүн шинжилгээ хийж цаашид сайжруулах зөвлөмж боловсруулж холбогдох бодлогод нөлөөлөх

Хөтөлбөрийн хугацаанд эдгээр байгууллагад мониторингийн үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ур чадварыг нь сайжруулах, тэднийг идэвхижүүлэх, нэг чиглэлээр тогтвортой ажиллан туршлага хуримтлуулахад нь хувь нэмэр болох зорилгоор аргагүйн сургалтыг хоёр удаа үе шаттайгаар зохион байгууллаа.

2012 оны 10 дугаар сараас эхэлсэн мониторингийн төслүүд оны эцсийн байдлаар бүрэн гүйцэд дуусаагүй байгаа боловч дараах зарим нэгэн дүгнэлт гарч байна. Тухайлбал, Ховд аймгийн Ажил олгогч эздийн холбоо Ховд аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг

дэмжих сангийн сүүлийн 3 жилийн зээл олголтод судалгаа хийж үзэхэд зээлийн хэмжээ жилээс жилд нэмэгдсэн ч зээл авсан иргэдийн тоо буурсан, удаа дараа хандаад зээл авч чадаагүй иргэд олон байхад нэг хүн давтан зээлд хамрагдаж байжээ. Түүнчлэн зээлийн хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагаа ил тод биш, зээл олголт удаашралтай, авсан зээлийн хэмжээ хүрэлцээгүйгээс зээлдэгчид зорьсон үйлдвэрлэлээ эхэлж чадалгүй өөр салбарт зээлээ эргэлтэд оруулдаг зэрэг олон зөрчилийг илрүүллээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хэмээн Нийгмийн халамжийн хуулийн 18.1-р заалтад 9 төрлийн

үйл ажиллагааг тодорхойлсон байдаг боловч “Түгээмэл хөгжил” ТББ-ын хийсэн мониторингийн дүнгээр холбогдох байгууллагууд нь сэргээн засах үйлчилгээ, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх гэсэн хоёрхон заалтыг голлон анхаарч ажиллаж байгааг илрүүлсэн байна. Тухайлбал, 2011 онд ОНОТХҮ-нд 3 тэрбум 47 сая төгрөгийг төсөвлөн зарцуулсан ба үүний 53 хувь нь зөвхөн сэргээн засах үйлчилгээнд, 30 хувь нь бүлгийн төслийн санхүүжилтэд, үлдсэн 17 хувь нь бусад 7 төрлийн үйлчилгээнд зарцуулагдсан байна. Үүний зэрэгцээ Багануур, Сонгинохайрхан дүүрэг, Дорноговь аймгийн НХҮХ-ийн ОНОТХҮ-ний мэргэжилтнүүд ч ОНОТХҮ гэдэг тодорхойлолтыг дээрх хоёр заалтаар голлон ойлгож үйл ажиллагаагаа явуулдаг ба харин энэ үйлчилгээг авах ёстой зорилтот бүлгийн нэг болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дан ганц сэргээн засах үйлчилгээ бус тэдний хэрэгцээ шаардлага тус бүрт нь нийцсэн өөр өөр төрлийн үйлчилгээ хэрэгтэй гэдгийг судалгааны дүн харуулж байна.

Өмнөговь аймаг дахь НДЭХ-ий салбар зөвлөл Өмнөговь аймгийн сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд мониторинг

хийж цэвэр усны төслөөр 29 сая 695 мянган төгрөгийн зээл авсан “Доод хайрхан” ХХК, “Блокны үйлдвэрлэл” төслөөр 2 сая төгрөгийн зээл авсан иргэн “З”, “Үхрийн ферм” төслөөр 2,8 сая төгрөгийн зээл авсан иргэн “С” нар эргэн төлөлт огт хийгээгүйг илрүүлсэн байна. Эдгээр зөрчил нь аймгийн ИТХ тус санд хяналт тавих үүрэгтэй орон тооны бус ажлын хэсгээ ажиллуулаагүй, сумын засаг дарга төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн

явц, түүний үр дүнд хяналт тавиагүйгээс үүссэн байна хэмээн дүгнэжээ. Түүнчлэн тус сангийн хөрөнгийн 50 гаруй хувийг ганц “Доод хайрхан” ХХК-ий цэвэр усны төсөлд олгосон нь ИТХ сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 3.1.3-т заасан нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоогоогүйгээс болсон байгааг илрүүлжээ.

Төв аймаг дахь НДЭХ-ий салбар зөвлөл иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах талаар баталгаажуулан зохицуулсан хууль,



Шатны хажууд хийсэн тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу зам хүнээр түрүүлээд гарсан ч осолдож болохоор маш аюултай болжээ. Энэ зургийг Түгээмэл хөгжил төвийнхөн Баянгол дүүргийн үйлчилгээний газруудаар явж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих налуу замыг хэрхэн хийсэнд үнэлэлт өгөх үеээр авсан юм. Үйлчилгээний газрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн налуу замыг заавал хийх ёстой гэсэн хуулийн заалт гараад удаж байгаа боловч барилга барьж байгаа компаниуд, аж ахуйн нэгж хуулиа хэрэгжүүлж налуу замыг стандартын дагуу хийхгүй байгаагийн нэгэн жишээ энэ юм. 2012 он.

тогтоомжийг аймаг, сум, багийн түвшинд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд мониторинг хийхдээ өөрсдийн боловсруулсан санал асуулгыг хэрэглэхийн сацуу төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх журмын зарим шалгуур үзүүлэлтийг ашигласан нь төрөөс хийсэн хяналт үнэлгээтэй харьцуулан харах боломжтой болжээ.

2012 оны мониторингийн төслүүд нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль батлагдсанаас хойш хийгдэж байгаагаараа онцлогтой бөгөөд энэ нь мониторинг хийхээр ажиллаж буй ТББ-уудад төрийн байгууллагаас шаардлагатай мэдээлэл хуулийн дагуу хүсч авах нөхцөл бүрдэж байгаа юм. Тухайлбал, 2010 онд авч байсан судалгаагаар мэдээлэл хүссэн 32 албан захидалд төрийн байгууллагаас огт хариу ирүүлээгүй буюу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан ба ийнхүү татгалзахдаа “ТББ-д мэдээлэл өгөх эрхзүйн орчин байхгүй”, “төрийн өөрийнх нь эрх бүхий байгууллагууд хяналт тавьж байхад ТББ хяналт тавих нь зохисгүй” гэх зэрэг тайлбар өгөх нь түгээмэл байсан. Харин 2012 онд мониторинг хийж байгаа ТББ ийм тайлбар аваагүй бөгөөд хэд хэдэн ТББ төрийн байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж ажлаа эхлүүлсэн байна.

2012 онд ННФ-ын мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрт оролцсон 20 ТББ-ыг оролцуулан төрийн байгууллагаас мэдээлэл авахад тулгарч буй бэрхшээлийн талаар судалж үзэхэд дараах дүр зураг харагдаж байлаа.

Эдгээр байгууллага төрийн янз бүрийн шатны байгууллагаас хэрэгжүүлсэн төслийнхөө хүрээнд төрийн үйлчилгээнд хөндлөнгийн мониторинг хийхэд шаардлагатай нийт 48 төрлийн мэдээлэл хүссэн байна. Үүнд, төсөв, түүний зарцуулалтын тайлан, төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр (ИТХ-ын тогтоол, засаг даргын

захирамж гэх мэт), аймаг сумын төрийн байгууллагуудын худалдан авалтын төсөв, гүйцэтгэл, ЖДҮ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн сангаас олгосон зээлийн шалгаруулалт, шалгарсан төслийн жагсаалт зэрэг мэдээлэл багтаж байна. Энэ нь өмнөх жилүүдэд төрийн байгууллагаас хүсч байсан мэдээллийн агуулгатай төстэй боловч энэ жилийн хувьд төрийн байгууллагын өөрийн дотоод хяналтын үйл ажиллагаанд (үндэсний хөтөлбөрүүдийн үнэлгээний болон мэргэжлийн хяналтын тайлан, байгаль орчны үнэлгээний болон ойн сангийн тайлан, ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ажлын тайлан мэдээ, эмнэлгийн байгууллагуудад шалгалт хийсэн хяналтын тайлан гэх мэт) давхар хяналт хийж ажилласан хэд хэдэн ТББ байсан.

Эдгээр иргэний нийгмийн байгууллага төрийн байгууллагын холбогдох ажилтнуудтай биечлэн уулзаж, төслөө танилцуулах зорилгоор уулзалт, дугуй ширээний ярилцлагыг удаа дараа хийх, хамтран ажиллах санамж бичиг үйлдэх зэргээр уйгагүй ажилласны үр дүнд нийт 48 хүсэлтийнхээ 40-д нь амаар болон бичгээр (54 хувь нь хүссэн


мэдээллээ эх хувиар нь авсан) хариугаа авч чадсан нь өмнөх жилүүдтэй харьцуулбал маш дэвшилттэй үзүүлэлт юм.

Харин 8 хүсэлтэд огт хариу өгөөгүй бөгөөд төрийн байгууллагаас мэдээлэл авахад маш их бэрхшээлтэй байдаг тухай судалгаанд оролцогчдын 20 хувь нь илэрхийлсэн байна. Хэдийгээр хүсэлтийнхээ ихэнхэд хариулт авч чадсан боловч энэ нь огт хүндрэл бэрхшээлгүйгээр тухайн мэдээллийг олж авсан гэсэн үг биш юм. Энэ тухай судалгаанд оролцогчдын 50 хувь нь мэдээлэл авахад боломжийн байсан боловч хүндрэл бэрхшээл учирсан гэж хариулжээ. Тухайлбал, төрийн ажилтнууд хүсэлтэд хариу өгөхөөс зайлсхийх, хугацаанд нь өгөхгүй удаашрах, өөр байгууллага руу хандуулах, аль нэг намын гишүүн эсэхийг асууж байж мэдээлэл өгөх зэрэг чирэгдэл учруулж байжээ. Ийнхүү мэдээлэл өгөхгүй, эсвэл хугацаанд нь өгч чадахгүй байгаагийн үндсэн шалтгаан нь төрийн байгууллагын ажилтнууд мэдээллээ хэрхэн иргэд, олон нийтэд өгөх тодорхой журамгүй, сонгуулийн үеэр ажилтнууд солигддог болж өмнөх ба одоогийн ажилтны хооронд мэдээлэл муутай, мэргэжлийн бус хүн ажилладаг, иргэдтэй


харилцах харилцааны соёл маш муу зэргээс болдог гэж таван ТББ хэлсэн байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад төрийн байгууллагаас мэдээлэл авах нь бэрхшээлтэй хэвээрээ гэж 45 хувь нь үзсэн байхад дөнгөж 25 хувь нь илүү сайжирсан гэж хариулжээ.

Мэдээллийн эрх чөлөөний хуулиар төрийн байгууллагууд мэдээллээ үндсэн дөрвөн чиглэлээр олон нийтэд нээлттэй тавихыг хуульчилж өгсөн билээ. Үүний дагуу төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах үүднээс мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажиллуулж байгаа ч гол төлөв цаг үеийн шинжтэй, хэт ерөнхий, олон нийтэд зориулагдаагүй бөгөөд харин төсөв санхүүгийн зарцуулалт, ажлын үр дүн, түүнчлэн иргэдийн оролцоог хангах зорилгоор урьдчилан зарлах зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа зэрэг нарийвчилсан мэдээллүүд нь огт байхгүй байгааг судалгаанд оролцогчдын 90 хувь нь илэрхийлсэн байна.

ТББ-ын хүссэн мэдээлэлд төрийн байгууллагаас хариу өгсөн байдал



Төрийн байгууллагуудын цахим хуудаснаас мэдээлэл авах боломж



## ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Төрийн ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой эрхзүйн орчин нэлээдгүй сайжирсан боловч эдгээр шинэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын туршлага хомс, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл дулимаг хэвээр байгааг харгалзан үзэж ННФ 2011 онд нийт 9 аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тухайн аймгийн төрийн бус байгууллагуудад санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлсэн юм. Дорнод, Дархан-Уул аймгийн НДЭХ-ий салбар зөвлөл, Төв аймгийн Ажил олгогч эздийн “Бизнес” холбоо, Өвөрхангай, Булган аймгийн ЛЭОС-ын салбар зөвлөл, Ховд аймгийн Булган сумын Бидний харгуй- Булганы ирээдүй, Хөвсгөл эрдэм төв, Дундговь Ардчилал клуб зэрэг төрийн бус байгууллагын идэвхитэй үйл ажиллагааны үр дүнд эдгээр аймагт ИТХ-ын дэг, зохион байгуулалт, үйл ажиллагаа улам боловсронгуй болж ирлээ.

Ийнхүү иргэдийн оролцоо, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр эхлүүлсэн ажлаа гүнзгийрүүлж, иргэдийн тогтвортой оролцоог хэвшүүлэх зорилгоор 2012 онд эдгээр байгууллага тус тусын аймагт төсвийн ил тод байдлыг хангахад төвлөрч ажиллав. Үүнд, төсвийн мэдээллийг иргэдэд нээлттэй болгохоос эхлэн иргэдийн оролцооны болон төлөөллийн байгууллагуудын үйл ажиллагааны дүрэм журмыг боловсронгуй болгож, орон нутагт мэдээллийн ил тод байдал тухайлбал, “Төсвийн тухай” шинэ хуулийг хэрэгжүүлэх явцын ил тод байдлыг хангах, иргэний нийгмийн байгууллагууд болон иргэдийн оролцооны чадавхийг дээшлүүлэх замаар иргэдийг орон нутгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, төсөвлөсөн болон зарцуулсан төсөвт хяналт тавих үр чадвартай болгох, иргэдээс гаргаж буй санал санаачлагыг шийдвэрт тусгуулах талаар хүчин чармайлт гаргалаа.

2012 оны 9 дүгээр сард зохион байгуулсан туршлага солилцох уулзалтын үеэр эдгээр байгууллага тус бүр хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүн, 2012 оны орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар хийх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцсэн юм. Хийсэн ажлын үр дүн, ололт амжилт, хүндрэл бэрхшээлийн талаар өгүүлсэн ярилцлагыг <http://participation.forum.mn> цахим хуудаст байрлуулаа. Эдгээр байгууллагын хоёр жилийн хугацаанд хийсэн ажлыг тусгайлан эмхтгэж тайлан болгон хэвлэхээр бэлтгэж байна.

### “Төсвийн ил тод байдал ба төсөвт иргэдийн оролцоог хангах” мониторингийн тайлангаас

Булган, Бугат, Орхон сум болон аймгийн төвийн төсвийн 20 гаруй байгууллагаас авсан судалгаанаас үзэхэд төсвийн гүйцэтгэлийг мэдээллийн самбараар бүх байгууллага, бүх ажилчдын хурлаар 88.2 хувь нь, вэбсайтаар зөвхөн нэг байгууллага мэдээлсэн байв. Ихэнх байгууллага төсөв боловсруулах, батлах шатанд санал авдаггүй байдал ажиглагдлаа.

Булган, Тэшиг, Рашаант, Баян-Агт, Сайхан сумдад “Сум хөгжүүлэх сан”, “Тогтвортой амьжиргаа төсөл” /ТАТ/-ийн хөрөнгийг захиран зарцуулах явцад иргэдийн оролцоог хангаж, орон нутгийн засаг, захиргаа болон иргэдийн үр ашигтай хамтын ажиллагааг бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэв. ТАТ-ийн хүрээнд иргэдийг хянагч, үнэлээчээр ажиллуулсан нь төсөвт иргэдийн оролцоог хангах тодорхой механизм бий болгосон чухал ач холбогдолтой ажил боллоо. Түүнчлэн олон нийтийн оролцоог хангасан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үр ашигтай, ил тод аргачлалыг бий болгож, иргэдийн нэн тэргүүний хэрэгцээнд тулгуурлан нийтийн эзэмшлийн байгууламжуудыг сайжруулах, төслөө олон нийт өөрсдөө ач холбогдлоор нь сонгох, эрэмбэлэх, хандив хөрөнгө бүрдүүлж хамтран санхүүжүүлж хэрэгжүүлдэг механизмыг нэвтрүүлсэн үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийхэд хамтран ажиллалаа.

Төслийн хугацаанд нийтдээ 20 гаруй байгууллага дээр Иргэдийн аудитын нэгж байгуулж, иргэдэд зориулсан хялбаршуулсан гарын авлага гаргасан нь тухайн байгууллагад ажиллагсад болон иргэд төсвийн үйл явцад оролцож, төсвийн үр ашгийг сайжруулахад хувь нэмрээ оруулах ач холбогдолтой боллоо. Иргэдийн аудитын нэгж нь зөвхөн төсвийн үйл явцыг нээлттэй болгох төдийгүй төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, тайланд иргэдийн оролцоо хангагдаж буй эсэхэд үнэлгээ өгч, төсвийн үр ашгийг сайжруулах чиглэлээр зөвлөмж гаргах эрхтэй байх юм. Түүнчлэн иргэдийн аудитын нэгж нь үйлчлүүлэгч, иргэний нийгмийн төлөөлөл, ИТХ-ын төлөөллөөс бүрдэх тухай төслийн багийн гишүүд зөвлөлдөж, цаашид шинээр байгуулагдах нэгжүүдийг ийм зохион байгуулалтад оруулахаар ярилцаж байна.

*ЛЭОС-ын Булган аймгийн салбар зөвлөл*

“Тунгалаг төсөв” төслийн хүрээнд орон нутагт хяналтын зөвлөлийг ажиллуулах журмын талаар сумын ИТХ-ын даргатай уулзаж ярилцсаны дүнд Хяналтын зөвлөлийг төсвийн шинэ хуульд заасны дагуу сайн дурын идэвхитэн иргэд, ААН, байгууллагын төлөөлөл, ТББ-тай хамтран есөн хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

*Ховд аймгийн Булган сумын “Бидний харгуй-Булганы ирээдүй” ТББ*



Баянхонгор аймгийн Төр захиргааны ордон, 2012 он. Гэрэл зургийг Д.Цэрэнжав



Дархан-Уул аймгийн “Дархан 50 цогцолбор”, 2012 он. Гэрэл зургийг Ө.Рагчаасүрэн



Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийн зарцуулалтыг хянах Мониторингийн асуумжаа боловсруулж байгаа нь. Түгээмэл хөгжил ТББ-ын ажилтнууд, 2012 оны 11 дүгээр сар, Өмнөговь аймаг.

Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Баянгол, Сант сумдад иргэдэд төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаар мэдээллийн самбар, орон нутгийн телевиз, радио, сонин хэвлэлүүдээр өгч буй мэдээллийн агуулгад дүн шинжилгээ хийхэд ихэнхдээ үйл ажиллагааны тайлан, тендер болон төсвийн гүйцэтгэл болоод өнгөрсөн үйл явдлын талаарх мэдээлэл иргэдэд хүрч байгаа нь тодорхой болов.

Тиймээс төслийн багийн зүгээс иргэд, олон нийт

болон орон нутгийн удирдлагуудын дунд хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулсны үр дүнд Арвайхээр сумын ЗДТГ-т “Иргэний танхим” байгуулах санаачлага гарсныг орон нутгийн удирдлага дэмжсэн юм.

Иргэд, олон нийтэд зөвхөн болоод өнгөрсөн үйл ажиллагааны тайлан, тендер болон төсвийн гүйцэтгэл төдийгүй, тэдгээрийг батлах үйл явцад иргэдийг оролцдог болгох зорилготой иргэний танхим байгуулагдан ажиллаж байна.

Дорнод аймагт ИТХ-ын дэргэдэх иргэний танхимыг тогтвортой ажиллуулах зорилгоор ИТХ-ын төлөөлөгч Д.Ганцогт, тэргүүлэгч Б.Хүрэлсүх нараар уламжлуулан 2012 оны төсөвт Иргэний танхимын үйл ажиллагааг хариуцах нэг ажилтны орон тоо, иргэдийн идэвхи оролцоог хангах нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулахад зориулж 2 сая төгрөгийг төсөвт тусгуулахад нөлөөлж ажиллалаа.

## ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

ННФ-ын дэмжлэгтэйгээр 2012 онд “Глоб Интернэшнл” ТББ, хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих, хэвлэлийн эрх чөлөөний мониторинг хийх, эрхзүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр хоёр жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж байна.

Уг төслөөр онлайн мониторингийн өөрөө мэдээлэх “self-alerting” тогтвортой системээр дамжуулан сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн тухай мэдээллийг олон нийтэд түгээж, нөлөөллийн кампанит ажил зохион байгуулах, мэргэжлийн эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдэд эрхзүйн тусламж үзүүлж, тэднийг хамгаалах, хөдөө орон нутгийн өмгөөлөгчдөд сэтгүүлчдийг өмгөөлөх чадвар эзэмшүүлэхийг зорьж ажиллаж байна. “Self-alerting” систем нь сэтгүүлчдэд тулгарч буй асуудал бэрхшээл, мэргэжлийн эрхийн зөрчлийн талаар өөрөө мэдээлж, эрхзүйн мэдлэг олж авах, үнэ төлбөргүйгээр эрхзүйн зөвлөгөө авах боломж олгож байгаа юм.

Орон нутгийн эрх мэдэлтнүүд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг дарамталж, эрхэндээ оруулах, нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад хяналт тавих, нөлөөлөх оролдлого хийдэг, нөгөөтэйгүүр тэнд сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага, өмгөөллийн бүтэц байдаггүй учир уг төслийн үйл ажиллагаа хөдөө, орон нутагт ажиллаж буй сэтгүүлчдэд түлхүү чиглэгдэж байгаа юм.

Төслийн үр дүнд хөдөө, орон нутгийн сэтгүүлчдийн эрхзүйн мэдлэг дээшлэн, тулгарсан бэрхшээл, мэргэжлийн эрхийн зөрчлийн талаар эрхийг нь зөрчиж буй албан тушаалтнаас эмээлгүй мэдээлэх, мэргэжлийн эрхээ хамгаалах дадал эзэмшиж, эрхзүйн үнэгүй зөвлөгөө авах боломж бүрдэх юм. Мөн хэвлэл мэдээлэл төвлөрсөн дөрвөн аймгийн найман өмгөөлөгч хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн өмгөөллийн тухай мэдлэг, ойлголттой болно.

## ЧӨЛӨӨТ ШУДАРГА СОНГУУЛЬ

Шинээр батлагдсан хуулийн дагуу явагдсан 2012 оны УИХ-ын ээлжит сонгууль нь өмнөх сонгуулиудтай харьцуулахад илүү шударга явагдах хэд хэдэн нөхцлийг хангаснаараа онцлогтой байлаа. Тухайлбал, сонгогчдын санал тоолоход анх удаа автоматжуулсан систем нэвтрүүлсэн ба сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэн үнэн зөв гаргах үүргийг УБЕГ-т хариуцуулж, улмаар жагсаалтыг хэсгийн хороод дур мэдэн хяналтгүйгээр өөрчилдөг явдлыг хориглосон билээ. Түүнчлэн тойрог, хэсэг, салбар хороодыг улстөрийн намуудын төлөөллөөс бус төрийн албан хаагчдаас бүрдүүлж, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгосон юм. Үүнээс гадна анх удаа иргэний нийгмийн байгууллагуудад санал хураах өдрийн үйл ажиллагааг ажиглах эрхийг олгосон нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангахад чухал ахиц дэвшил авчирсан өөрчлөлт байв.

Энэхүү нааштай өөрчлөлт, дэвшил гарахад 2007 онд Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр байгуулагдсан

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн байгууллагуудын сонгуулийн үйл явцад хийж ирсэн хөндлөнгийн мониторинг, түүний дүгнэлт, зөвлөмж, нөлөөллийн үйл ажиллагаа багагүй хувь нэмэр болсныг дурдах нь зүйтэй. 2012 онд СЕХ сонгуулийн шинэ хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой журам боловсруулахад дээр дурдсан сүлжээний гишүүд идэвхийлэн оролцсон юм. Уг журамд сонгуулийн үйл явцад мониторинг хийх ТББ нь юуны өмнө улстөрийн нам, эвслээс хараат бус, бие даан үйл ажиллагаа явуулж тодорхой туршлага хуримтлуулсан, байгууллагын дүрэмдээ тухайн чиглэлээр ажиллах үүрэг зорилттой, хяналт шинжилгээ хийх ажлын төлөвлөгөөтэй байх зэрэг шалгуурыг заавал хангасан байхаар тусгасан. Түүнчлэн СЕХ-ны зүгээс мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудад сонгогчдын нэрийн жагсаалт болон түүнийг нягтлан шалгах, өөрчлөлт оруулах үйл явц хуулийн дагуу хийгдэж байгаа эсэхтэй танилцах, сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэл, шийдвэртэй танилцах, хуулбарлан

авах, санал хураах, тоолох төхөөрөмжийн ажиллагааг туршин шалгах үйл явцыг хянах, сонгуулийн хороодод ирсэн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар мэдээлэл авах, саналын хуудас хэвлэх, хадгалалт хамгаалалт, тээвэрлэлт, аюулгүй байдал, битүүмжлэн хадгалах ажиллагаанд хяналт тавихад дэмжлэг үзүүлэхээр журамд тусгасан билээ.

Сүлжээний гишүүн байгууллагууд 2004 ба 2008 оны сонгуулиудаар хуримтлуулсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан сонгуулийн үйл явцад зөрчил, маргаан гарч болзошгүй гэж үзсэн асуудлуудад гол анхаарал хандуулснаас гадна УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуульд туссан сонгуулийн үйл явцыг боловсронгуй, ил тод болгохтой холбоотой зарим чухал заалтын хэрэгжилтийг хянах зорилгыг мөн дэвшүүлэн дараах таван чиглэлээр мониторинг хийлээ.

### 1. САНАЛЫН ХУУДАС ХЭВЛЭХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, ХҮРГҮҮЛЭХ, АРХИВТ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН МОНИТОРИНГ

Сонгуулийн дүнг гаргах үндсэн баримт бичиг болох саналын хуудастай холбогдох будлиан, маргаан сонгуулиас сонгуульд нэмэгдэх хандлагатай болж ирсэн. Иймээс “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн байгууллагууд 2008 онд саналын хуудас хэвлэх, багцлах, тойрог хэсгийн хороодод хүргүүлэх үйл явцыг хянасан бөгөөд 2012 оны сонгуулиар энэхүү асуудалд НДЭХ ТББ хяналт хийлээ.

2008 оны сонгуулийг угтан дээрх сүлжээний гишүүн байгууллагууд саналын хуудастай холбогдсон будлиан гарахаас сэргийлэх зорилгоор саналын хуудсыг нэгдсэн индекс дугаартай болгох, багцалж дэвтэрлэх

зөвлөмжийг бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талуудад хандан гаргаж байв. Үүний дүнд саналын хуудсыг тусгай нууцлал бүхий усан хээтэй цаасан дээр хэвлэх болсноор “канондаж” хуулбарлах боломжгүй болсон ч хуурамч гарын үсэгтэй хуудсууд саналын хайрцагас гарч ирсэн баримт байдаг. Ийм асуудлууд гарах гол шалтгаан нь саналын хуудасны тоо, ашиглалтад тавих хяналт сул байсантай холбоотой. 2008 оны сонгуулийн мониторингийн дүнгээс харахад хэвлэх үйлдвэрт саналын хуудсыг алдаатай тоолж багцалдаг, түүнчлэн СЕХ холбогдох журамдаа нөөц саналын хуудсыг сонгогчдын тооноос 10 хувиар их тогтоодог, тойрог, хэсгийн хороод 2-5

хувийн нөөцтэй захиалдаг, ингэсээр эцэстээ хяналтгүй маш олон саналын хуудас тойрог, хэсгийн хороодод очдог болох нь нотлогдсон юм. Нөгөө талаас, саналын хуудасны ашиглалтад тавих хяналт маш сул байв.

Сонгуулийн шинэ хуулиар саналын хуудсыг индекс дугаартай болгосон нь дэвшилттэй өөрчлөлт болсон юм. 2012 оны сонгуулиар НДЭХ ТББ саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах хүргүүлэх хамгаалах журам гаргах, хэвлэх компанийг сонгон шалгаруулах, саналын хуудсыг хэвлэх, багцлах, хүлээлгэн өгөх үйл явц, нөөц хуудасны ашиглалтын асуудлыг хамруулан мониторинг хийж дүгнэлт гаргав.

Хэвлэлийн компанийг сонгон шалгаруулахдаа дан ганц техникийн шалгуур үзүүлэлтийг харгалзсан нь учир дутагдалтай бөгөөд компанийн эзэд сонирхлын зөрчилгүй, улстөрөөс хараат бус байх зэрэг шалгуур үзүүлэлтийг орхигдуулсан байв.

Мөн сонгуулийн байгууллага болон хэвлэх үйлдвэрийн буруугаас нийт саналын хуудасны бараг 40 хувийг дахин хэвлэсэн бөгөөд үүнтэй холбоотой зардлыг хэн хариуцах, хэн хариуцлага хүлээх талаар ямар ч зохицуулалт байхгүй, тэр хэрээр төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагджээ.

*Сонгуулийн мониторингийн тайлангаас*

## 2. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН МОНИТОРИНГ

Иргэний нийгмийн байгууллагууд 2008 ба 2012 оны сонгуулиудаар сонгогчдын нэрийн жагсаалтад мониторинг хийн үлэмж хэмжээний зөрчил илрүүлж, засаж залруулахад нөлөөлж ирсний үр дүнд УИХ-ын сонгуулийн шинэ хуульд сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэн гаргах үүргийг УБЕГ-т бүхэлд нь хариуцуулж, сонгуулийн хэсгийн хороод дураараа өөрчлөлт оруулахыг хориглосон юм.

Дээрх нааштай өөрчлөлтийн үр дүнг бодитой хэмжих үүднээс 2012 оны сонгуулиар “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн “Филантропи төв” ТББ сонгогчдын нэрийн жагсаалтад дахин мониторинг хийлээ. Мониторингийг хүн ам ихтэй, шилжин суурьшигч олонтой гэсэн шалгуур үзүүлэлтээр УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойрог буюу Сонгинохайрхан дүүргийн 45,330 сонгогчтой 20 хэсгийн хороог сонгож ажиглав.

УИХ-ын сонгуулийн тухай хуулиар зөөврийн хайрцагар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих нөхцөл бүрдсэн хэдий ч холбогдох журам нь хугацаа хоцорч батлагдсаны улмаас мониторингийн баг зөөврийн хайрцагар санал өгөх сонгогчдын жагсаалтыг нягтлах боломжгүй болсон.

УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 25-р хэсгийн хорооны нэг хаягт 40 сонгогч бүртгэлтэй байсныг шалган нягтлахад таван тусдаа нийтийн байранд нийт 14 өрхийн 30 сонгогч оршин суудаг нь тодорхой болж харин сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 10 сонгогч тухайн хаягт огт байхгүй байв. Түүнчлэн жагсаалтад бүртгэлгүй 6 сонгогч байв. Мөн БЗД-ийн 20-р хорооны нэг хаягт 169 сонгогч бүртгэгдсэн тухай мэдээлэл ирүүлснийг нягтлан шалгахад бүртгэлийн байгууллага тухайлсан хаяггүй өрхүүдийг нэг хаягт нэгтгэн бүртгэсэн гэж мэдээлсэн ба бодит байдалд айлууд нь тус тусдаа хаягтай байлаа.

Сонгуулийн мониторингийн тайлангаас

## 3. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТЫН МОНИТОРИНГ

2012 оны УИХ-ын сонгуулийн санал тооллогыг будлиангүй явуулж сонгуулийн дүнг нэгтгэн зарлах үйл явцыг хурдасгах, хүний оролцоог аль болох багасгах зорилгоор анх удаа автомат төхөөрөмжөөр сонгогчдын саналыг тоолох шийдвэрийг УИХ-аас гарган 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хуулийг баталсан билээ.

Ийнхүү сонгуулийн үйл ажиллагаанд анх удаа автомат тоологч машин, шинэ цахим үнэмлэх, хурууны хээ ашиглахтай уялдан гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сонгуулийг шударга явуулахад хувь нэмэр оруулах зорилгоор “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн МИДАС ТББ сонгуулийн автоматжуулсан системийн ажиллагаанд мониторинг хийсэн юм.

Автоматжуулсан системийг шалгах, тестлэх, гэрчилгээжүүлэх болон төхөөрөмжийн засвар үйлчилгээ, нөөцийн хуваарилалтыг зохих түвшинд сайн зохион байгуулсан гэж мониторингийн багийнхан дүгнэв.

## 4. САНАЛ ХУРААХ, ТООЛОХ, ДҮН ГАРГАХ ҮЙЛ ЯВЦЫН АЖИГЛАЛТЫН МОНИТОРИНГ

Өмнөх сонгуулиудаар сонгогчдын санал хураах, тоолох ажиллагааг зөвхөн нам, эвсэл, нэр дэвшигчдийн томилсон ажиглагчид, түүнчлэн гадаадын байгууллагууд ажиглах эрхтэй байсан ба дотоодын иргэний нийгмийн байгууллагуудад энэ нь бүхэлдээ хаалттай байв. УИХ-аар 2011 онд батлагдсан Сонгуулийн шинэ хуулиар иргэний нийгмийн байгууллагуудад санал хураах өдрийн үйл ажиллагааг ажиглах эрх олгогдсоны дагуу “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд” ТББ 2012 оны УИХ-ын сонгуулийн санал хураах, тоолох, дүн гаргах

үйл явцыг ажиглалаа. Уг сүлжээний зүгээс хуулийн дагуу, аль болох өргөн хүрээнд ажиглалт хийхийн зэрэгцээ залуучуудыг олноор татан оролцуулж чадавхижуулахыг зорьсон болно. “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд” ТББ-ын манлайлал дор сайн дурын 200 залуучуудаас бүрдсэн баг нийслэлийн 112 хэсгийн хороонд сонгуулийн өдөр суурин ажиглалт хийв. Эдгээр хэсгийн хороодод 2012 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн санал авах, тоолох, дүнг гаргах ажиллагаа хуулийн дагуу явагдсан ба сонгуулийн дүнд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй байна.



“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүд мониторингийн явц болон ажиглалтын үр дүнгийн талаар хэвлэлийн бага хурал хийж байгаа нь, 2012 оны 6 дугаар сар.



“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд” ТББ-ын манлайлал дор ажилласан сонгуулийн ажиглалтын багийнхан, 2012 оны 5 сарын 29.

## 5. СОНГУУЛИЙН ҮЕИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

Ардчилсан сонгуульд хэвлэл мэдээлэл нь үзэл бодлын чөлөөт индэр болж, нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн байр суурийг олон нийтэд ойлгуулахаас гадна зөв сонголт хийхэд нь тэдэнд туслах чухал үүрэгтэй билээ. Монголын хэвлэл мэдээлэл энэхүү чухал үүргээ зохих түвшинд биелүүлэх, сонгогчдод хүрч буй мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангахад тодорхой хэмжээнд нөлөөлөх, далд сурталчилгааг илрүүлэхэд төрийн бус байгууллагуудын зүгээс хийж ирсэн сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн мониторинг нь чухал ач холбогдолтой болов.

2012 оны УИХ-ын сонгуулиар “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн “Глоб Интернэшнл” ТББ телевизүүдээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд мониторинг хийлээ. Сонгуулийн хуульд шинээр орсон “Олон нийтийн радио телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна” гэсэн заалтыг үндэслэн СЕХ, ХХЗХ хамтран радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам баталж хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээсэн юм.

МҮОНТ болон орон даяар нэвтрүүлгээ цацдаг, үзэгчдийн тоо, рейтинг өндөр, зах зээлд удаан хугацаагаар оршин тогтнож үйл ажиллагаа явуулж буй, зөвхөн агаарын долгион ашигладаг шалгуурыг үндэслэн UBS, ТВ5, ТВ9, 25-р суваг телевизийн нэгдүгээр сувгуудыг сонгож 6 дугаар сарын 6-наас 26-ны өдрийн сонгуулийн сурталчилгаанд мониторинг хийсэн байна.

Өмнөх сонгуулиудаар хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн аргачлалд тулгуурлан сонгуулийн шинэ хууль, СЕХ, ХХЗХ-ны хамтран баталсан “Олон нийтийн

радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-д нийцүүлж боловсруулсан арга зүйн дагуу мониторингийг хийв. Мониторингийн баг сургалтад хамрагдаж, “Ажиглагчийн ёс зүйн зарчим”-ыг баримтлан ажиллав.

СЕХ-оос баталсан хуваарийн дагуу 2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааг МҮОНТ нийт 23 цагт багтаан 21 өдөр явуулахаар төлөвлөжээ. 13 нам тус бүр 21 өдөрт 1 цаг буюу 3 удаагийн давтамжтай 20 минутын нэвтрүүлэг явуулахаар хуваарилжээ. Үлдсэн 10 цагийн 1 цаг 30 минутыг бие даан нэр дэвшигчдэд, 8 цаг 30 минутыг дахин 13 нам, эвсэлд тэнцүү хуваарилсан нь нэг намд дунджаар 40 орчим минут оногджээ.

*Сонгуулийн мониторингийн тайлангаас*

Мониторингоор сонгуулийн нийт мэдээлэл, түүний дотор нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгааны хувь хэмжээ, мэдээллийн өнгө аяс, оргил цагийн хуваарилалт болон мэдээний хөтөлбөрт нам, эвсэл, нэр дэвшигчдийн тухай мэдээллийн эзлэх хувь, далд сурталчилгаа, төлбөртэй нэвтрүүлгийн хуулийн хязгаарлалтын хэрэгжилт, сонгуулийн сурталчилгаанд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь зэргийг гаргасан юм.

Дээрх таван чиглэлээр хийсэн мониторингийн дүнг тоймлон үзэхэд хууль зөрчсөн ноцтой алдаа, анхаарал татсан томоохон зөрчил ажиглагдаагүй хэдий ч цаашид анхаарч үзвэл зохих зүйлүүд байсныг тэмдэглэх нь зүйтэй. ННФ эдгээр таван чиглэлийн мониторингийн дүн, зөвлөмжүүдийг нэгтгэн хэвлүүлж олон нийт, холбогдох байгууллагуудад хүргүүлжээ. Мониторинг тус бүрийн дэлгэрэнгүй дүн болон цаашид авч хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөмжүүдийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас авч үзнэ үү.

# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР

## ОЛБОРЛОХ САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС) амжилттай үргэлжлэн хэрэгжиж Олборлох салбарын үндэсний 6 дахь тайлан олон нийтэд хүрлээ. Энэхүү санаачлагад Монгол Улс нэгдэн орсноос хойш ННФ-ын зүгээс идэвхитэй дэмжин ажиллаж байгаа билээ. 2012 онд ОУИТБС-ын хэрэгжилтийг чанаржуулах, хамрах хүрээг тэлэхэд онцгой анхаарч Төлсөн авснаа нийтэл эвсэл (ТАН эвсэл)-тэй хамтран ОУИТБС-ын 2006 оноос хойш гарсан үндэсний бүх тайланд дүн шинжилгээ хийж, санаачлагын хэрэгжилтийг сайжруулах талаар дорвитой зөвлөмж гарган, ОУИТБС-ын Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Судалгааны үр дүнд ОУИТБС-д компаниудыг бүрэн хамруулах, төлбөрийн мэдээллийн баазыг зохистой хэлбэрт оруулж, улмаар олон нийтийн хэрэглээг дэмжих зэрэг асуудлаар тодорхой зөвлөмж гаргасныг ОУИТБС-ын Ажлын хэсэг, Ажлын алба зэрэг нэгжүүд шийдвэрлэхээр ажиллаж байна. Тухайлбал, ОУИТБС-ын 2011 оны тайланд 500 орчим компанийн мэдээлэл агуулагдаж байсан бол 2012 онд 1500 орчим болж эрс өөрчлөлт гарах хандлагатай байна.

ОУИТБС-ыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх талаар өмнөх онд хийсэн ажлын туршлагад тулгуурлан сумын түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх туршилтын уулзалтууд “ТАН”

эвсэлтэй хамтран Баянхонгор аймгийн Баян-Овоо, Галуут сумдад зохион байгуулагдав. Тус сумдад үйл ажиллагаагаа явуулж буй уул уурхайн компаниуд сумын төсөвт төлж буй төлбөр болон хөгжилд оруулж буй хөрөнгийн талаар иргэдэд тайлагнасан бол сумдын захиргаа хүлээн авсан орлого, хандив тусламж зэргийн хэмжээ, тэдгээрийг хэрхэн зарцуулсан тухай тайлан гаргаж, цаашид ийм арга хэмжээг тогтмол зохион байгуулж байхаар тохиролцлоо. Орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар хуримтлуулсан өмнөх туршлага, дээрх уулзалтуудын үр дүнд үндэслэн сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурал, бусад удирдлага, сонирхогч талуудад зориулсан гарын авлагыг бэлтгэх ажлыг эхлүүлээд байна.

ННФ нь ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан хангах үүрэг бүхий ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж Үндэсний зөвлөлийн хоёр удаагийн, Ажлын хэсгийн дөрвөн удаагийн хуралдаанд, мөн аудиторыг сонгох үнэлгээний хорооны үйл ажиллагаанд идэвхитэй оролцлоо. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, иргэний нийгмийн ижил тооны төлөөллийг эдгээр бүтцэд өөрсдийн шийдвэрээр томилдог журмыг гаргахад

нөлөөлөл үзүүлсэн нь цаашид иргэний нийгмийн байгууллагууд эдгээр бүтцэд ажиллах төлөөллөө өөрсдөө сонгож хараат бусаар ажиллах аятай нөхцөл бүрдүүлэв.

Олон улсын түвшинд ОУИТБС-ын хувьд цөөнгүй улс орон шинээр нэгдэн орж, хэрэгжүүлэгч улс орон болсноос гадна санаачлагын хэрэгжилтийн явцад хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ОУИТБС-ыг хэрэгжүүлэх шалгуур, дүрмийг өөрчлөх ажил хийгдлээ. ННФ нь ОУИТБС-ын Олон улсын удирдах зөвлөлийн гишүүнээр дөрөв дэх жилдээ ажиллаж буй өөрийн төлөөллөөр дамжуулан ОУИТБС-ыг олон улсад ийнхүү үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. ННФ-ын ажилтан Н. Дорждарь ОУИТБС-ын Олон улсын удирдах зөвлөлийн санхүүгийн хороонд идэвхитэй ажиллаж,

ОУИТБС-ын санхүүжилт, төсөв бүрдэлт, зарцуулалтын үйл явцыг боловсронгуй болгох талаар онцгойлон анхаарч ирлээ. Тэрчлэн ННФ-ын зүгээс ОУИТБС-д нэгдэн орох бэлтгэлийг хангахад Тажикстан Улсын иргэний нийгэм, олон талын оролцоот бүлгийн ажлыг дэмжиж, сургалт, хэлэлцүүлэг зэрэгт оролцож, Монгол Улсын туршлагаас хуваалцлаа.

ОУИТБС-ын эрхзүйн орчныг бэхжүүлэх талаар нөлөөллийн ажил явуулахад ихээхэн анхаарч ажиллалаа. Тухайлбал, ОУИТБС-ын тухай бие даасан хууль гаргах талаар дэмжиж, ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын алба, мөн ЕСБХБ-ны төслийн хүрээнд хамтран ажиллаж, хуулийн төсөлд тусгайлан санал бэлтгэх, түүнчлэн өөрсдийн төлөөллийг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оруулан ажиллаж ирэв.

ОУИТБС-ын тайлан, өгөгдлийг ашиглах явдлыг сайжруулах зорилгоор дараах санал зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

ОУИТБС-д олборлох салбарын бүх компаниуд оролцох явдлыг Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн зүгээс хангах шаардлагатай байна.

- Бүтээгдэхүүн, борлуулалтын хэмжээ, хүлээн авсан хандив, дэмжлэг, бусад “сайн дурын” төлбөр, тухайлбал хөрөнгө оруулалтын зардал, байгаль орчныг хамгаалах зардал зэргийн хувьд, түүнчлэн лиценз, бүтээгдэхүүн ба борлуулалт зэрэг тайлангийн маягтын мэдээллийг бүрэн тайлагнахгүй байгааг нягталж залруулах шаардлагатай байна.
- Компаниудын хийсэн төлбөрийг чухам ямар төсөвт, тухайлбал ямар орон нутгийн төсөв, түүнчлэн төр захиргааны ямар байгууллагад төлөгдсөн болохыг хянах боломжтой байхаар тайлангийн маягт, үйл явцыг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг өөрчлөх шаардлагатай.
- Сангийн яам болон төр захиргааны бусад байгууллага, агентлагийн олборлох салбараас хүлээн авсан орлогын тухай гаргадаг мэдээлэлтэй ОУИТБС-ын өгөгдлийг харьцуулан уялдуулж, ийм мэдээлэл зөрүүтэй байгаа шалтгааныг Засгийн газрын зүгээс тайлбарлах шаардлагатай.
- ОУИТБС-ын хүрээнд Засгийн газар, компаниуд, аудиторудын гаргасан тайлангийн мэдээллийг хадгалж буй хэлбэрийг өөрчлөх талаар ОУИТБС-ын Ажлын алба анхаарч ажиллах шаардлагатай.
- ОУИТБС-ын өгөгдлийн санг ашиглан судалгаа, шинжилгээний тайланг Ажлын албанаас бэлтгэж, оролцогч тал, сонирхогч олон нийт тус сангаас ямар мэдээлэл авах боломжтойг харуулах шаардлагатай.

ОУИТБС-ын өгөгдлийн үнэн бодит байдал, хэрэглэгчид ашиглахад энгийн байдлыг сайжруулах талаар ОУИТБС-ын Ажлын албанаас онцгойлон анхаарах шаардлагатай.

*“Өгөгдлийн уурхай” судалгааны зөвлөмжөөс*

## УУЛ УУРХАЙН ОРЛОГЫГ УДИРДАХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Олборлох салбарын орлогыг хянах институцийн тогтолцоог бүрдүүлэх эрхзүйн орчныг сайжруулах, бодит амьдралд уг тогтолцооны хэрэгжилтийг хангахад тус салбарын орлогод хяналт тавих шалгуур, үзүүлэлтүүдийг тодорхойлох нь нэн чухал ач холбогдолтой.

АНУ-д төвтэй Орлогын ажиглагч хүрээлэнгийн боловсруулсан аргачлалын дагуу Монгол Улсын орлогын менежментийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гаргаж, цаашид тогтмол мониторинг хийхэд ашиглахад бэлэн болгоод байна. Үүнд, улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, өр зээлийн хэмжээнд тавигдах хязгаарыг хянах, түүнчлэн уул уурхайн орлоготой ямар нэгэн байдлаар уялдаатай бүрддэг буюу зарцуулагддаг Тогтворжилтын

сан, Хөгжлийн сан, Хөгжлийн банк зэрэг бүтцийн хувьд суурь үзүүлэлтүүдийг цуглуулсан билээ. Цаашид эдгээр суурь үзүүлэлтийг шинэчлэх, тухайлбал орон нутгийн төсөвт хуваарилагдах уул уурхайн орлогын зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой өөрчлөлт оруулах зэрэг ажлыг 2013 онд үргэлжлүүлэн хийх юм.

Тэрчлэн байгалийн баялаг ихтэй олон улс орны орлогын менежментийн тогтолцоог харьцуулан судалдаг Орлогын ажиглагч хүрээлэнгээс эрхлэн хийдэг Орлогын Ажиглагч Индексийн судалгааны ажилд хөндлөнгийн хяналт тавьж оролцоо. Уг судалгааны дүнг 2013 оны эхний хагаст багтаан зарлахаар төлөвлөж байна.



Сэлэнгэ аймгийн “Болдтөмөр Ерөө гол” уурхай 2012 он.  
Гэрэл зургийг Д.Цэрэнжав

## УУЛ УУРХАЙН ТАТВАР, ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ЭРХЗҮЙН ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ

Ашигт малтмалын хуулийг өөрчлөх талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал санаачлага гарган, шинэчилсэн хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байгаа билээ. ННФ-ын зүгээс уг төсөлтэй холбогдуулан санал шүүмж бэлтгэж, хэвлэл мэдээлэл болон олон нийтийн уулзалт хэлэлцүүлгээр дамжуулан байр сууриа илэрхийллээ.

Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай

1. Хуулийн төслийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч олон тооны тайлан, мэдээллийг бэлтгэн төрийн байгууллагад өгөх тухай зохицуулалтууд хийгджээ. Ийнхүү мэдээллийн урсгал нэмэгдэж байгааг дэмжиж байгаа ч нэг талаас тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөгөө талаас төр засаг аль аль нь мэдээллээ олон нийтэд ил тайлагнадаг байх зарчим тэр бүр үйлчлэхээргүй байна. Өөрөөр хэлбэл, төр засаг олон төрлийн мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулан авч байгаа ч зарим хэсгийг нь тодорхой нэмэлт нөхцөлтэйгээр олон нийтэд мэдээлэх, мөн төрийн байгууллагад бүрэлдэх тайлан мэдээг тэр бүр олон нийтэд хүргэхгүй байх нөхцөл бүрэлдэх боломжтой нь ажиглагдаж байна.
2. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт мэдээллийг олон нийтэд ил тод хүргэхэд чиглэсэн зарим санаачлагууд хэрэгжиж ирсэн. Ялангуяа олон улсад хэрэгжиж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагад Монгол Улс нэгдэн орж, мэдээллийн ил тод байдлын дэвшилтэт стандартыг нэвтрүүлээд байна. Уг стандартын үндсэн зарчим нь төр засаг, компани аль аль нь иргэд, олон нийтэд мэдээллээ хүргэх ажлыг иргэний нийгмийн оролцоотой хэрэгжүүлэх явдал билээ. Уг санаачлагыг хэрэгжүүлж ирсэн туршлагад үндэслэн, цаашид энэхүү ил тод байдлын стандартыг үйл ажиллагааны ердийн соёл болгон хэвшүүлэх зорилгоор эрхзүйн орчныг нь боловсронгуй болгох таатай нөхцөл уг хуулийн төслийг хэлэлцэж байгаатай холбоотойгоор үүсч байна.
3. Олон нийтэд ил тайлагнах мэдээллийн агуулга, чанар, цар хүрээ, цаг хугацаа, шат дамжлага, хариуцах эзэн зэргийг хуулийн хүрээнд дэлгэрэнгүй зохицуулж өгөх нь хуулийн хэрэгжилтийг хангах, уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавихад иргэдийн оролцоог хангах нөхцлийг бүрдүүлэх юм.

*Ашигт малтмалын хуулийн төсөлд өгөх ННФ-ын санал шүүмжийн хэсгээс*

## ОЛБОРЛОХ САЛБАРЫН БОДЛОГЫГ ИДЭВХИТЭЙ ХЯНАХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

ОУИТБС-ын үйл ажиллагаанд шууд ба шууд бусаар оролцдог иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх нь ННФ-ын үйл ажиллагааны чухал хэсэг юм. Тэр тусмаа ТАН эвслийн чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь бүх талын дэмжлэг үзүүлж ирлээ. Тухайлбал:

- “ТАН” эвслийн ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт орсон гишүүдтэй эдгээр бүтцийн хуралдааны өмнө тогтмол уулзаж, мэдээлэл солилцдоогоос гадна нөлөөллийн стратеги боловсруулахад нь хамтран ажиллалаа.
- ТАН эвслийн зохицуулагчийг урамшуулах болон өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг ННФ-аас санхүүжүүлж, хэд хэдэн төсөлд хамтран ажиллав. Түүнчлэн ТАН эвслийн гишүүдэд зориулсан мэдээлэл түгээх, вэб сайт ажиллуулах, сургалт зохион байгуулах ажлуудыг тогтмол хийж ирлээ.
- Төв Ази, Кавказын “Төлснөө нийтэл” сүлжээний жил тутмын уулзалтад ТАН эвслийн гишүүд идэвхитэй оролцлоо.

- ТАН эвслийн гишүүн бус ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүн болох Монголын Байгаль орчныг хамгаалах иргэний зөвлөлийн төлөөлөгчийг Азербайжан Улсын Баку хотноо зохион байгуулагдсан Орлогын ажиглагч хүрээлэнгийн ОУИТБС-ын дунд шатны сургалтад оролцууллаа. Түүнчлэн ОУИТБС-ын өгөгдөл, мэдээллийг ашиглах талаар хоёр өдрийн сургалт ТАН эвслийн гишүүдэд зориулан зохион байгуулав.

- Бүс нутгийн болон олон улсын хүрээнд Төлснөө нийтэл олон улсын сүлжээний байгууллагууд идэвхитэй хамтран ажиллаж ирсэн. 2012 онд Төлснөө нийтэл сүлжээний бүх гишүүдийн уулзалт болж, уг сүлжээний шинэ стратегийг хэлэлцэн батлав. Түүнчлэн энэ стратегийг бэлтгэх ажлын хүрээнд бүс нутгийн Төлснөө нийтэл сүлжээний гишүүдийн уулзалтыг зохион байгуулахад Монгол Улсын “Төлсөн авснаа нийтэл” сүлжээний гишүүд идэвхитэй оролцлоо. Цаашилбал, Төв Ази, Кавказын Төлснөө нийтэл сүлжээний гишүүдийн уламжлалт уулзалтад ТАН эвслийн

гишүүд оролцсон, олон улсын харилцааны хувьд ихээхэн үр бүтээлтэй жил болов.

- Иргэний нийгмийн бусад байгууллагад зориулан Орлогын менежментийн талаар сургалт явуулах, сургалтад дэмжлэг үзүүлэх ажлыг гүйцэтгэлээ. Интерньюс байгууллага, Хэвлэлийн хүрээлэн хамтран сэтгүүлчдэд зориулан зохион байгуулсан сургалтад ННФ-ын зүгээс ОУИТБС-ын болон ТАН эвслийн талаар танилцуулга хийж, уул уурхайн орлогын менежментийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оролцогчдод танилцууллаа. Сургалтад оролцогчид ОУИТБС-ын талаар тусгайлсан мэдээ, нэвтрүүлэг бэлтгэх ажлыг уг сургалтын дүнд хийж гүйцэтгэв.

## ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Төсвийн ил тод, нээлттэй байдал, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог бий болгох талаар иргэний нийгмийн байгууллагууд шаардлага тавьдаг, төр засаг тодорхой хэмжээнд анхаардаг болсноор 2010-2012 онд дэс дараатай шинэчлэгдсэн төсвийн хууль тогтоомжид төсвийн үйл явц болон мэдээллийг нээлттэй болгох талаар хэд хэдэн заалт орсон. Ялангуяа Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам” зэрэг баримт бичигт урьд өмнө байгаагүй тодорхой зохицуулалтыг хийж өгсөн. Мөн “Орон нутгийн хөгжлийн сан” нэрээр нийслэл, дүүрэг, аймаг, сумдад төсөв буюу орлогын шилжүүлэг хуваарилж хэрхэн зарцуулахыг нь тухайн иргэдээр нь баг, хорооны түвшинд хэлэлцүүлж байхаар Төсвийн тухай хууль, түүнийг дагалдуулж гаргасан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д тусгасныг 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээр ийм хэлэлцүүлгийн явцад тухайн төсвийн хэмжээ ба хуваарилалт тодорхой хэмжээнд нээлттэй болж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийг баталсантай холбогдуулан хуулийн төслүүдэд байр сууриа илэрхийлэн идэвхитэй оролцож, санал бодлоо өгч байсны хувьд эдгээр хуулийн хэрэгжилтийн талаар ННФ хэд хэдэн ажил төлөвлөн хийж байна. Төсвийн тогтвортой байдлын хууль амьдралд бодитой хэрэгжиж чадвал төсвийн алдагдал багасах, засгийн газрын өрийн хэмжээ өгөөжтэй түвшинд байхуйцаар хянагдах, төсвийн орлогын эмзэг байдал буурах зэрэг ач холбогдол бүхий хууль болсон. Тиймээс эдгээр хуулийн бодит хэрэгжилт чухал бөгөөд үүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй.

Өнгөрсөн хугацаанд ННФ “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ болон “Ил тод байдлын сан” ТББ-тай хамтран Дэлхийн Банкны санхүүжилтээр “Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах загвар стандарт” төслийг хэрэгжүүллээ. Уг төслийн хүрээнд Монгол Улсын орон нутгийн төсвийн баримт бичиг ба үйл явцыг бодитойгоор ил тод, нээлттэй болгоход чиглэгдсэн загвар

стандарт боловсруулж Ховд аймгийн Ховд, Дөргөн сум болон Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэгт туршлаа. Энэхүү загвар стандартыг боловсруулах, турших, олон нийтэд хүргэхэд орон нутгийн төр, захиргаа болон төсөв, санхүүгийн ажилтнуудын идэвхитэй оролцоо нэн чухал байлаа.

Загвар стандартыг боловсруулахад дараах үндсэн зарчмыг удирдлага болгосон юм. Үүнд: i) Монгол Улсын хууль тогтоомж, төсвийн холбогдолтой бодлогын баримт бичиг, хуулиуд, тэдгээрийг дагалдаж гарсан дүрэм журамд тусгалаа олсон орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын зарчим, шаардлагад бүрэн нийцэх, ii) төсвийг ил тод, нээлттэй болгох, ингэхдээ оролцогч талуудын бүтээлч хамтын ажиллагаанд тулгуурлах, iii) орон нутгийн төр, захиргаа, төсвийн байгууллагын мэдээлэл боловсруулах, түгээх боломж, чадавхид зохицох, iv) орон нутгийн иргэд, татвар төлөгчид, тэдний идэвхитэй хэсэг болсон төрийн бус байгууллагуудын төсвийн мэдээллийг байнга хүлээн авч хяналт тавих, төсвийн үйл явцад оролцох, санал хүсэлт,

байр сууриа илэрхийлэх эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэх, v) хямд төсөр, хүртээмжтэй байх, цаг хугацаа хэмнэх, vi) Монгол Улсын хууль тогтоомжид гарч байгаа өөрчлөлт, шинэ эрэлт хэрэгцээ, мэдээллийн арга хэрэгслүүдийн хөгжилтэй уялдуулж өөрчлөх боломжтой байх зэрэг болно.

Энэхүү стандартын талаарх мэдээллийг олон нийт, бодлого боловсруулагчид, төр засаг, төсвийн байгууллагын ерөнхий захирагчдад хүргэх талаар идэвхийлэн ажиллаж эхлээд байна. Үүнд, нийт сум, аймаг, дүүрэг, нийслэлийн засаг дарга болон ИТХ-ын дарга нар оролцсон “Шууд ардчилал - Иргэдийн оролцоотой төсвийн менежмент үндэсний сургалт, зөвлөлгөөн” дээр дэлгэрэнгүй танилцуулга хийлээ. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газраас тусгайлан зохион байгуулсан Улаанбаатар хотын нийт 9 дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон хэлэлцүүлэгт загвар стандарт, түүнийг нэвтрүүлэх арга замын талаар дэлгэрэнгүй танилцуулав. Цаашид Улаанбаатар хот болон Сангийн Яамтай хамтраад мэдээллийг иргэдэд түгээх, төслийн үр дүнг тогтвортой, өгөөжтэй байлгах зорилго бүхий томоохон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна.

Дэлхийн улс орны төсвийн ил тод, хариуцлагатай байдал ба иргэдийн оролцоог хэмждэг “Нээлттэй төсвийн судалгаа 2012” тайлангийн үр дүнг “Олон улсын төсвийн түншлэл” байгууллагаас зарлалаа. Энэхүү тайлан дахь Монгол Улсын судалгааг ННФ хийдэг бөгөөд энэ удаад манай улс бага зэрэг ухарсан үзүүлэлтэй гарлаа. Энэхүү судалгаа, үнэлгээний үр дүнд тус байгууллага нэлээд тодорхой зөвлөмжүүд гаргасан болно.

Монгол Улс энэхүү судалгаанд анхнаас нь буюу 2006 оноос хамрагдаж ирсэн бөгөөд нийт авах ёстой 100 онооноос 2006 онд 18, 2008 онд 36, 2010 онд 60, харин 2012 онд 51 оноо тус тус авч өмнөх амжилтаасаа ухарсан дүнтэй гарсан байна. 51 оноо нь


Монгол Улсын Засгийн газар тухайн жилийн улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар зарим мэдээллийг л олон нийтэд өгдөг болохыг харуулж буй үзүүлэлт юм.

Монгол Улсын Засгийн газар төсвийн урьдчилсан мэдэгдэл, батлагдсан төсөв, гүйцэтгэх засаглалын төсвийн санал, явцын тайлангууд болон жилийн эцсийн тайлан, аудитын тайланг нийтэлдэг бол харин хагас жилийн тоймыг дотоод хэрэгцээнд зориулж хийдэг ба иргэдэд зориулсан төсвийг огт боловсруулдаггүй байна.

Монгол Улсын хувьд Казакстан, Киркистан зэрэг бүс нутгийн зарим улстай харьцуулахад хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллагын чадавхи хүчтэй гэсэн үнэлгээг авсан боловч төр засгийн хамгийн

Нээлттэй төсвийн судалгаа нь түүнд хамрагдсан улс орны төв засгийн газруудын төсвийн найман гол баримт бичгийг олон нийтэд ил тайлагнасан байдал, мөн эдгээр баримт бичигт орсон мэдээллийн иж бүрэн, шуурхай, ашиглаж болохуйц байдалд үнэлгээ өгдөг. Энэхүү индекс нь дэлхийн хүн амын 89 хувь буюу 100 орны засгийн газрын төсвийн ил тод байдлын талаарх дэлхийн цорын ганц хараат бус, харьцуулсан хэмжигдэхүүн юм.

0-100 хүртэл: Монгол Улс төсвийн найман гол баримт бичигт орсон мэдээллийн хэмжээг нэмэгдүүлсэн үү?



Нээлттэй төсвийн судалгааны тайлангаас

их ярьж анхаарч буй төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо үзүүлэлтээр сул дүнтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, төсвийн төлөвлөлт, хэлэлцэн батлах үйл явц, гүйцэтгэл ба хяналт зэрэг бүх шатанд иргэдийг оролцуулах механизм байхгүй, зарим нэг эхлэл санаачлага байгаа боловч хэрэгжилт, чанар сул, нээлттэй сонгол хийдэггүй, олон нийт ямар нэг хэлбэрээр саналаа илэрхийлсэн байлаа ч тэдний саналыг тусгасан талаарх гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллага, аудитын байгууллагаас гаргасан мэдээлэл байхгүй байгаа юм.

Түүнчлэн 2011 онд шинээр зарлагдсан Төсвийн ил тод байдлын төлөө даян дэлхийн санаачлагыг үүсгэн байгуулагчдын нэг тул энэ онд ННФ энэхүү санаачлагын хоёр дахь удаагийн уулзалтад идэвхитэй оролцож, цаашид төсвийн ил тод, нээлттэй байдлын стандартуудыг сайжруулах олон улсын шилдэг туршлагыг Монголдоо хэрэгжүүлээд зогсохгүй энэ талаар хуримтлуулсан мэдлэг, туршлагаа бусад гишүүн улстай хуваалцах, туршлага солилцох боломжтой боллоо. Төсвийн ил

тод байдал, оролцоог олон улсын түвшинд таниулах, ухуулах, мэдээлэх зорилго бүхий төрөл бүрийн үйл ажиллагаанд зохион байгуулагчид ННФ-ыг нэг чухал нэмэлт хүч хэмээн үзэж байгаа юм.

Түүнчлэн төсвийн мэдээллийг олон нийтэд дөхөм байдлаар хүргэх, энэ чиглэлээр төлөвлөн хийж буй ажлын талаарх мэдээлэл, үр дүнг бусдад түгээх, төсөв, санхүүгийн асуудлаар олон нийтийн санал бодлыг сонсох, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор Facebook сошиал медиаг ашиглан “My Budget-Миний төсөв” хэмээх хуудсыг ажиллуулж байна.



“My Budget-Миний төсөв” FACEBOOK хуудас

Улс	Хууль тогтоох байгууллагын чадавхи	Аудитын дээд байгууллагын чадавхи	Олон нийтийн оролцоо
Азербайжан	Дунд зэрэг	Сул	Сул
Гүрж	Хүчтэй	Хүчтэй	Дунд зэрэг
Казакстан	Хүчтэй	Сул	Сул
Киргизстан	Дунд зэрэг	Дунд зэрэг	Сул
Монгол	Хүчтэй	Хүчтэй	Сул
Орос	Хүчтэй	Хүчтэй	Сул
Тажикстан	Хүчтэй	Хүчтэй	Сул
Украин	Дунд зэрэг	Хүчтэй	Сул

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) хуудаснаас үзнэ үү.

## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ННФ нь эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадвар, бизнесийн орчин, орон нутгийн эдийн засгийн хөгжил зэрэг макро эдийн засгийн бодлогын асуудлаар судалгаа шинжилгээ хийж, олон улсын харьцуулсан судалгаанд түнш байгууллагаар хамтран ажиллаж, бодлого боловсруулагчид, эдийн засагчид, бизнесийн салбарын төлөөлөгчид, иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага өрнүүлж ирлээ. Энэ хэрээр эдгээр сэдэв олны анхаарал татаж төрийн бодлогод тусгалаа олж, улмаар зарим их дээд сургуулийн хөтөлбөрт тусгай хичээл болгон оруулаад байна. 2012 оноос эхлэн ННФ-ын анхаарч ирсэн төсвийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар төсвийн удирдлагын хариуцлагатай байдлыг дээшлүүлэх ажилдаа түлхэц өгөх, нөгөө талаар Монгол Улсын өрсөлдөх чадварыг тодорхойлох макро эдийн засгийн чухал асуудал болохын хувьд төсөв, сангийн бодлогод дүн шинжилгээ хийхэд түлхүү анхаарч

ажиллалаа. Энэ хүрээнд “2013 оны төсвийн төслийн тойм судалгаа, үнэлгээ”, “Төсвийн бодлогын макро эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ”, “Зээлийг хөгжил болгоход анхаарах зарим асуудал” сэдэвт судалгаа захиалан хийлгэж уулзалт хэлэлцүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бодлого боловсруулагчдад болон олон нийтэд хүргэлээ.

Орлогын менежментийн асуудалд олон нийтийн анхаарлыг татах, нийтийн тэр тусмаа нөхөгдөшгүй баялаг болох эрдэс баялгийн салбараас орж буй орлогыг зохистой, үр өгөөжтэй зарцуулахад иргэдийн

зүгээс оролцох боломжийг өргөтгөх, улмаар бодлого боловсруулагчдад нөлөөлөх, сонгуулийн үед сонгогчид илүү хариуцлагатай сонголт хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өмнөх онд боловсруулсан Монгол Улсын орлогын менежментийн асуудлаарх эдийн засгийн сценарийн дөрвөн хувилбарыг сошиал медиагаар болон сэтгүүл болгон хэвлэж иргэд, олон нийт, бодлого боловсруулагчдад хүргүүллээ. Энэхүү сценари нь олны анхааралд өртөж нэлээд уншигдсанаас гадна энэ төрлийн сценари боловсруулах ажил чухал болох нь Рио Тинто болон





## БИЗНЕСИЙН ОРЧИН

Дэлхийн эдийн засгийн форумын эрхлэн гаргадаг Өрсөлдөх чадварын индекс 2012 оныхоо тайланг 9 дүгээр сарын 5-нд дэлхий даяар танилцуулсан. ННФ уг байгууллагын түнш байгууллагаар 8 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд тус тайлангийн Монгол Улсын


бизнесийн байгууллагын удирдах ажилтны дунд явуулах судалгааг Хүман Фортис Консалтанси компанитай хамтран явуулдаг. Өрсөлдөх чадварын энэхүү индекс нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл бөгөөд Монгол Улсын өрсөлдөх чадварыг ижил

Манай Улс уг судалгаанд 2005 оноос хамрагдаж эхэлсэн бөгөөд 2012-2013 оны судалгаагаар 3.9 оноогоор 144 орноос 93-р байрт жагссан нь 2011 онд 142 орноос 96-р байрт орсон үзүүлэлтээ сайжруулсан мэт харагдаж байгаа ч өмнөх онд авч байсан ерөнхий оноогоо ахиулж чадаагүй юм.

Монгол Улс 12 тулгуур асуудлын ихэнхэд буюу макро эдийн засгийн тогтвортой байдлаас бусад үзүүлэлтээрээ ахисан дүнтэй байна. Макро эдийн засгийн тогтвортой байдлын оноо 5.4-өөс 4.9 болон буурч 34-өөс 52 буюу 18 байраар ухарсан бөгөөд үүнд гол нь төсвийн алдагдал ДНБ-ий 3,6 хувь (өмнөх онд 1.2 хувь байсан), засгийн газрын өрийн хэмжээ ДНБ-ий 20.3-аас 47.1 хувь болж өссөн нь хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн байна. Бусад үзүүлэлтээр үндэсний хуримтлал ДНБ-ий 36.7-оос 48 хувь болж өссөнөөр энэ үзүүлэлтээр дөрвөн байраар ахиж 7 дугаарт орлоо. Улсын зээлийн үнэлгээ 36.3-аас 33.9 болж буурсан нь гурван байраар ухарч 95 дугаар байр эзлэхэд хүргэжээ. Есдүгээр тулгуур асуудал болох технологийн бэлэн байдлын хувьд Монгол Улс томоохон амжилт гаргаж түүрүү жил авч байсан оноо нь 3.1 –ээс 3.8 болон даруй 32 байраар зэрэглэлээ ахиулсан байна. Урагш ахисан

бусад үзүүлэлтэд шүүхийн хараат бус байдал (+10), төр засгийн зохицуулалтын дарамт (+12), маргаан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийн үр ашигтай байдал (+12), төрийн бодлого боловсруулалтын ил тод байдал (+12), компанийн удирдах зөвлөлийн үр ашигтай ажиллагаа (+10), гар утасны бүртгэл (+13), бага боловсролын хамрагдалт (+71) болон бусад тулгуур хүчин зүйлс болох бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал, инноваци зэрэг орж байна.

Судалгаанд хамрагдсанаас хойшхи хугацаанд ДӨЧИ-д эзэлсэн Монгол Улсын зэрэглэл



Дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.

төстэй улс орнуудтай харьцуулах боломж олгохын зэрэгцээ тухайн улсын өрсөлдөх чадварын өсөлт, бууралт, тогтмол байдлын талаарх мэдээллийг өгдөг. Мөн зэрэглэлд хамрагдсан улс өрсөлдөх чадварын зэрэглэлээ тодорхойлох, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг сайжруулах, шинэчлэх боломжийг олгодог.

Монгол Улсын эзэлж буй байр, авсан оноо нь өрсөлдөх чадварыг тодорхойлох 110 үзүүлэлтийн олон хүчин зүйлийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байгаа ба ялангуяа манай улсыг хойш чангаан 120-иос хойш байр эзэлж буй асуудлуудыг тусгайлан анхаарах хэрэгтэй байгааг сануулж байна. Мэдээж нэг дор, богино хугацаанд олон асуудлыг шийдэж чадахгүй тул бид хөгжлийн

аль шатанд яваагаа шинжлэн үндсэн хэрэгцээ болсон суурь болон үр ашгийг дээшлүүлэх хүчин зүйлд түлхүү анхаарах хэрэгтэй.

ННФ судалгааны үр дүн, зэрэглэлийг олон нийт, шийдвэр гаргагчид болон холбогдох талуудад хэвлэлийн хурал хийх, сонирхсон хэвлэл мэдээлэлд тусд нь ярилцлага өгөх замаар түгээв. Энэхүү олон жилийн судалгааны ажлын үр дүнд бодлого боловсруулагчид болон бусад талууд энэ сэдвээр өргөн дэлгэр яриа өрнүүлдэг, судалгааны үр дүнг ашигладаг болсон. Тухайлбал, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо судалгааны зэрэглэл, үр дүнг энэ талаарх төрийн бодлогыг сайжруулах, бодлогын шинэтгэл хийх ажлынхаа үндэс суурь болгон ашигладаг.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС		2011-2012		2012-2013		Өөрчлөлт
Тайланд хамрагдсан орны тоо		142		144		
Үзүүлэлт		Байр	Оноо	Байр	Оноо	
Монгол Улсын өрсөлдөх чадварын зэрэглэл		96	3.9	93	3.9 →	+3
ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ, СУУРЬ ХҮЧИН ЗҮЙЛС		101	4.2	92	4.2 →	+9
1-р тулгуур	Институцийн тогтолцоо	119	3.2	113	3.3 ↑	+6
2-р тулгуур	Дэд бүтэц	118	2.7	112	2.8 ↑	+6
3-р тулгуур	Макро эдийн засгийн тогтвортой байдал	34	5.4	52	4.9 ↓	-18
4-р тулгуур	Эрүүл мэнд, суурь боловсрол	98	5.4	76	5.6 ↑	+22
ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХҮЧИН ЗҮЙЛС		105	3.6	96	3.8 ↑	+9
5-р тулгуур	Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт	84	3.9	83	4.0 ↑	+1
6-р тулгуур	Бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал	92	4.0	85	4.2 ↑	+7
7-р тулгуур	Хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал	31	4.7	33	4.7 →	-2
8-р тулгуур	Санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал	129	3.2	127	3.3 ↑	+2
9-р тулгуур	Технологийн бэлэн байдал	102	3.1	70	3.8 ↑	+32
10-р тулгуур	Зах зээлийн хэмжээ	124	2.4	116	2.6 ↑	+8
ИННОВАЦИЙГ ДЭМЖИХ ХҮЧИН ЗҮЙЛС		112	3.0	112	3.1 ↑	0
11-р тулгуур	Бизнесийн боловсронгуй байдал	119	3.2	121	3.3 ↑	-2
12-р тулгуур	Инноваци	102	2.8	100	2.9 ↑	+2

# НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

## НИЙГМИЙН БОДЛОГО

*2012 онд ННФ-ын нийгмийн бодлогын хөтөлбөр нийгмийн үйлчилгээний хүргэлтэд хяналт мониторинг тавих төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажилласны зэрэгцээ залуучуудын санаачлага, оролцоог дэмжихэд гол анхаарлаа төвлөрүүлээ.*

*Мөн боловсролын салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Боловсролд тэгш хамруулах зарчмыг Монголд хэрэгжүүлэхэд тус болох судалгаа, шинжилгээ, мониторингийн ажлуудыг эхлүүлээд байна. Боловсролын салбарт мөн гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн үйл явц, үр нөлөөг үнэлэх аргачлалыг боловсруулаад байна.*

## НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ БА ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

Нийгмийн үйлчилгээний хүргэлтэд мониторинг хийх иргэний нийгмийн чадавхи бэхжүүлэх зорилтын хүрээнд 2011 онд хөдөө орон нутгийн ТББ-уудыг чадавхижуулахад төвлөрсөн бол 2012 онд залуучуудын оролцоог дэмжихэд анхаарлаа. Залуучуудын амьдралд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг шийдэх арга замуудыг судалж, тодорхой нэг шийдлийг туршин хэрэгжүүлэхэд нь арга зүйн болон санхүүгийн дэмжлэг

үзүүлэх зорилготой энэхүү хөтөлбөрт залуучуудын ТББ төдийгүй хувь залуучуудыг оролцуулахыг хичээсэн юм.

Хөтөлбөрт оролцохоор сонирхлоо илэрхийлсэн 15-29 насны хот, хөдөөгийн 30 гаруй залуусыг нэг өдрийн арга зүйн сургалт семинарт урьж оролцууллаа. 2012 оны 4 дүгээр сард зохион байгуулсан энэхүү сургалт семинараар нийтийн эрх ашиг, иргэдийн оролцоо зэрэг сэдвээр богино

хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ мониторинг, бодлогын судалгаа, орон нутагт үйлчилгээ үзүүлэх төсөл боловсруулах зэрэг арга зүйг танилцуулав. Энэхүү сургалтад Иргэний боловсрол төв ТББ оролцож, орон нутагт тулгамдаад байгаа асуудлаар иргэд хамтран санал боловсруулж хэрэгжүүлэх зорилготой “Иргэн” төслийн аргазүйг танилцуулж, туршлагаасаа хуваалцлаа. Энэхүү сургалт семинар нь залуу хүмүүсийн

иргэний идэвхи санаачлагыг өрнүүлэхэд дэмжлэг болохын зэрэгцээ тэдэнд аргазүйн мэдлэг өгсөн ач холбогдолтой болов. Хөтөлбөрийн хүрээнд энэ жил 4 төсөл шалгарснаас 3 нь хэрэгжиж байна. Үүнд:

*Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд туслах сайн дурын сүлжээ байгуулах туршилтын төсөл.* А.Энхцолмон агсан санаачлан Д. Цолмон хэрэгжүүлж байгаа “Итгэл” төсөл нь их дээд сургуулийн Оюутны холбоо, сайн дурын оюутнуудын тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй оюутны тусгай хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг турших зорилготой юм. Чингис Соосэ сургуулийн нэгдүгээр дамжааны оюутан Д.Цолмон нь тэргэнцэртэй оюутныг автобуснаас тосож авах, суулгаж өгөх, хичээлийн хуваарийн дагуу танхим хооронд шилжих, мөн хичээлийн бус цагаар номын сан, үзвэр үйлчилгээний газар хүргэн өгч, авах зэрэг ажлыг сайн дураар гүйцэтгэх оюутнуудыг клубын хэлбэрээр зохион байгуулж байна. 2013 оны 6 дугаар сар хүртэл туршилтын журмаар хэрэгжих энэ төслийн эцэст ижил төрлийн үйлчилгээг зохион байгуулахад ашиглаж болох заавар зөвлөгөө боловсруулж гаргахын зэрэгцээ ийм үйлчилгээг сургуулийн дотоод журамд тусган заавал хэрэгжүүлдэг болоход чиглэсэн нөлөөллийн ажил хэрэгжүүлэх юм. ННФ нь Д.Цолмонд төслөө хэрэгжүүлэхэд нь санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тодорхой асуудлаар мэдээлэл цуглуулах, мэргэжлийн хүмүүстэй холбогдон санал зөвлөмж авахад нь тусалж ажиллалаа.

*Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагаанд хийсэн мониторинг.* Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Гүнж төв ТББ-ын залуу эмэгтэйчүүд “Хүчирхийллийн хохирогчдод хүргэх үйлчилгээг сайжруулах нь” төслийг 6 сарын хугацаанд хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод мэргэжлийн үйлчилгээг нэг дор, багаар үзүүлэх зорилгоор 2009 онд байгуулагдан ажиллаж байгаа эмнэлэг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний гурван төвийн үйл ажиллагаанд мониторинг

хийжээ. Эдгээр төвийг тохижуулах, эмч, цагдаа, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг сургахад ДЭМБ-аас 17,5 сая төгрөг, НҮБ-ын Хөгжлийн алтан сангаас 48,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бол төвүүд нь байгуулагдсанаасаа хойш 400 гаруй хүнд үйлчилж, 58 үйлчлүүлэгчийг түр хамгаалах байрт илгээж, 78 хэрэгт холбон зуучилж, 5 хүнийг хөдөлмөр халамж үйлчилгээний газраар дамжуулан ажлын байртай болгосон байна. Харин хүний нөөц дутмаг, ажиллагсдын цалин урамшууллыг төсөвт суулгадаггүй, багаар ажиллаж чадахгүй үйлчлүүлэгчдэд чирэгдэл учруулж байгаа зэрэг нь эдгээр төвийг цаашид тууштай ажиллуулах боломжгүй болгож буйг судалгааны баг онцолжээ. Гүнж төв ТББ-ын залуу эмэгтэйчүүд энэхүү мониторингийн үр дүнг бодлого боловсруулагчдад хүргэх нөлөөллийн ажлыг 2013 онд хэрэгжүүлэх бөгөөд цаашид ч залуучуудад чиглэсэн төрийн болон нийгмийн үйлчилгээний хүргэлтэд мониторинг хийх төлөвлөгөөтэй байгаа юм.

*Бодлого, шийдвэр боловсруулах үйл явцад оролцох залуучуудын оролцоог дэмжих төсөл.* 13-26 насны залуучуудын үүсгэл санаачлагаар байгуулагдсан Хүүхэд хүүхдийн төлөө ТББ нь янз бүрийн түвшний шийдвэр гаргах үйл явцад идэвхитэй оролцох арга зүйд өөрийн байгууллагын гишүүд, бусад залуучуудыг сургах зорилготой “Залуусын оролцоо” төслийг нэг жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Өөрийн байгууллагын залуучуудыг бодлогын асуудлаар үзэл бодлоо үндэслэлтэй илэрхийлэхэд сургаж, туршлага олгох зорилгоор нийтлэлч хүүхдүүдийн клуб байгуулан, эхний удаад залуучуудын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн бүрдүүлж буй дүр төрх, хөндөж буй асуудлуудад мониторинг хийж, багаар болон бие даан богино нийтлэлүүд бичих ажлыг гүйцэтгэж байна. Хэд хэдэн нийтлэл гарсны дараа хөндөгдсөн асуудлуудаар залуучуудын дунд хэлэлцүүлэг хийж, бодлогын шийдэл боловсруулж шийдвэр гаргагчдад хүргэх нөлөөллийн ажил төлөвлөөд байгаа болно.

## БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ



Ерөнхий боловсролын 29-р тусгай сургуулийн хичээлийн явцаас, 2012 он. Гэрэл зургийг н. Түвшин.

ННФ нь боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, мөн энэ салбарт ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлд анхааран ажилладаг билээ. Эдгээр үйл ажиллагаа нь боловсролын салбарын бодлого, үйл ажиллагааг олон талын оролцоо, хөндлөнгийн хяналттай болгохын зэрэгцээ салбарын бодлого, шийдвэрт иргэний нийгмийн байгууллагуудыг мэдлэг мэдээлэлтэй оролцоход нь дэмжлэг болох зорилготой юм.

Сурч боловсрох эрх нь зөрчигдөн, суурь боловсрол эзэмшиж чадахгүй хоцорч байгаа хүүхдүүдийн талаар өмнөх жилүүдэд хуримтлуулсан туршлагадаа үндэслэн “Боловсролд тэгш хамруулах зарчим”-ыг өөрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон томъёоллоо. Энэ нь бусад хүүхэдтэй эн зэрэгцэн суралцаж чадахгүй байгаа хүүхдүүдэд тохиолдож буй саад тотгорыг арилгах замаар боловсролын тогтолцоог хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэх, сургуулийг алагчилал, ялгаварлан гадуурхалтаас ангид орчин болгоход бодлого, үйл

ажиллагаагаа чиглүүлэхийг шаарддаг хүний эрхэд суурилсан хандлага юм.

Энэ зарчмын дагуу бид боловсролд хамрагдаж чадахгүй байгаа нийгмийн бүлгүүдийг тодорхойлсны үндсэн дээр тэдэнд тулгарч байгаа саад тотгорыг арилгахад чиглэсэн бодлогын арга хэмжээг боловсруулах зорилготой цуврал үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2012 оны 9 дүгээр сард Латви Улсад туршлага судлах аялал хийхдээ гурван сургуулийн үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ оролцогч таван улсын төлөөлөгчдөөс

мэдээлэл, туршлага судалж ирсэн нь Боловсролд тэгш хамруулах зарчмыг хэрэгжүүлэхэд ННФ-аас хийх үйл ажиллагааг төлөвлөх, бусад ТББ-тай үйл ажиллагаагаа уялдуулахад томоохон дэмжлэг боллоо. Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ-тай хамтран бид сургуулийн түвшинд хэрэгжүүлж болох арга зүй, энгийн хялбар хэрэглэгдэхүүнүүд агуулсан эх сурвалж материалыг англи хэлнээс орчуулж эхлээд байгаа ба 2013 онд үүний дагуу сургалт, туршилт, мэдээллийн болон нөлөөллийн ажил хийхээр төлөвлөөд байна.

Боловсролд тэгш хамруулах бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар хязгаарлагдахгүй ч Монголд өнөөдөр хэрэгцээндээ нийцсэн боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа хамгийн том бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд юм. Тийм учраас 2012 онд бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрох эрхийг хангах бодлогын шийдэл гаргахад төвлөрч ажиллалаа. ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээгээр аль болох бага наснаас нь тууштай хангаж өгөх, ингэхдээ эмнэлэг, нөхөн сэргээх болон нийгмийн халамжийн үйлчилгээтэй уялдуулан цогцоор нь хүргэх тогтолцооны загвар боловсруулах судалгааны ажлыг дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгээд байна. Судалгаа нь бусад улс оронд тогтолцоо болж хэвшсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан хөгжлийн хөтөлбөр, эрт илрүүлэлт, эцэг эхийн боловсрол зэрэг хэд хэдэн багц асуудлыг олон улсын сайн туршлагаудад түшиглэн тайлбарлаж, манай улсад хэрэгжүүлэх боломжтой тогтолцооны нэг хувилбар болгон гаргаж тавьжээ. Судалгааны багийн гишүүд судалгаа хийх явцдаа бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангах, санал зөвлөмжөө шууд

хүргэх замаар нөлөөллийн ажил идэвхитэй хийж ирсний үр дүнд энэ нь 2013 оны эхээр боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн хуулинд оруулсан зарим өөрчлөлтийн суурь болсон юм.

Тэрчлэн 2012 онд бид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоотой хамтран Улаанбаатар хотод байгаа тусгай сургуулиудын сургалтын орчинд мониторинг хийх, төрийн бус байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх орон нутагт түшиглэсэн загваруудыг нэгтгэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих санаачилгуудын эх сурвалж” ном гаргахаар ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд үйлчилгээ үзүүлэх, эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэх чиглэлээр голлон ажилладаг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбоотой ННФ хамтран бодлогын нөлөөллийн үйл ажиллагаа явуулах юм.



Ерөнхий боловсролын 29-р тусгай сургуулийн сурагч, 2012 он. Гэрэл зургийг н. Түвшин.

# X

## ӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

ННФ-ын Хөгжлийн Мэдээллийн төв 2012 онд онлайн үйлчилгээг өргөтгөхөд түлхүү анхаарч ажиллалаа. Энэ хүрээнд (i) онлайн мэдээллийн сангаа өргөтгөх; (ii) сан хөмрөгт байгаа мэдээллийг зарим тодорхой сэдвээр багцлан байрлуулж байна.

Өнгөрсөн онд гадаадын дараах онлайн сангуудын ашиглалтын лицензийг шинээр авч, мөн заримыг сунгав. Үүнд: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Кэмбрижийн сэтгүүлүүд, Оксфордын лавлах болон толь бичгүүд, Олон улсын валютын сан болон Дэлхийн Банкны и-номын сангуудыг манай мэдээллийн төвийн үйлчлүүлэгчид 2015 он хүртэл үнэ төлбөргүй ашиглах эрхтэй боллоо.

Тус мэдээллийн төвөөс эрхлэн баяжуулдаг судалгааны онлайн санд одоогоор Монголын нийгэм, эдийн засгийн холбогдолтой 1000 гаруй судалгааны тайлан, үнэлгээ байна.

Эдгээр мэдээллийн ашиглалт сүүлийн жилүүдэд харьцангуй нэмэгдэж байгаа ба 2012 онд нийт 213 500 гаруй хэрэглэгч хандсанаас 26 657 нь ямар нэг судалгаа мэдээлэл татаж авчээ.

Харин хэвлэмэл ном, судалгааны тоо хэмжээ төдийлөн өргөжөөгүй ч тодорхой зорилготой, судлаач хэрэглэгчдийн хэрэгцээнд зориулан онлайн каталогид бүртгэгдсэн 4300 орчим ном, материалаас нийтдээ 107 200 удаа хайлт хийжээ.

2012 онд сан хөмрөгөөс тухайн цаг үед хэлэлцэгдэж буй асуудлаарх мэдээллийг түүвэрлэн багц мэдээллийг үүсгээд байна.

Гишүүнчлэлийн тоо өмнөх оноос 30 үйлчлүүлэгчээр нэмэгдэн 180 хүн энэ үйлчилгээг сонгож давхардсан тоогоор 301 үйлчлүүлэгч 1450 ном, судалгааг гэрээр авч ашигласан байна.

2012 онд хэвлэмэл мэдээллийн ашиглалт бага зэрэг буурсан боловч онлайн мэдээлэл үзэх хандалтын тоо

30000 орчимоор нэмэгдсэн нь цаашид онлайн сангийн мэдээллийг өргөжүүлж, чанаржуулах шаардлагатайг илтгэн харуулж байна.



## ОРТАЛ САЙТ

“Нээлттэй Нийгэм Форум” портал сайт нь Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах, бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг чиглэлээр 2004 оноос эхлэн ажиллаж стратегийн хүрээнд тогтмол шинэчлэгдэж ирлээ. 2012 онд сайтын дизайнд шинэчлэл хийж доорх бүтцээр мэдээллээ баяжуулав.

“Чухал сэдэв” буланд сонгууль, төсөв, уул уурхай зэрэг Монголын хөгжлийн асуудлаарх мэдээ мэдээлэл, ярилцлага, нийтлэл, өгүүллийг олны хүртээл болгодог бөгөөд нийтдээ 600 гаруй мэдээлэл байгаагаас 110 гаруй нь 2012 онд шинээр нэмэгджээ.

- Сонгууль 2012 хуудас: Улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаарх шүүмж анализ,

сонгуулийн үйл явцын мониторинг зэрэг өргөн хүрээтэй мэдээ материалыг энэ хуудсанд нэг дор байрлуулан, олон нийтэд түргэн шуурхай танилцах боломжийг бүрдүүлж, мэдээллийг багцаар нь хүргэж байна.

- Төсөв хуудас: Тус портал нь 2004 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний тодотголтой холбоотой багц мэдээллийг тогтмол толилуулдаг болсон. Тухайн жилийн улсын төсвийн дэлгэрэнгүй төслийг бүрэн эхээр нь вэб сайтад байрлуулж, олон нийтийн саналыг нь хүлээн авч байна.

“Бодлогын хэлэлцүүлэг” буланд хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог боловсронгуй болгоход чиглэсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслүүд, ашгийн бус байгууллагын тухай хуулийн төсөл, Ашигт малтмалын тухай хуулийн төсөл, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Төрийн нууцын тухай хуулийн төсөл, Сонгуулийн үйл явцын эрхзүйн зохицуулалт зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор тэдгээртэй холбоотой баримт бичиг, судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилууллаа.

“Эх сурвалж” буланд тайлант хугацаанд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 50 орчим шинэ судалгаануудыг бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн ННФ-аас бодлогын асуудлаар хэвлэн гаргаж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцууллаа.

# Б

## ОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Өмнө нь их дээд сургуулийн эрдэмтэн багш нар, төрийн албан хаагчид хамрагдах боломжтой байсан Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр 2012 оноос иргэний нийгмийн судалгаа, шинжилгээний чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдэх боллоо. Анх уг хөтөлбөрийг санаачлан эхлүүлж байсан 2003 оны байдалтай харьцуулахад бодлогын судалгааны тухай мэдлэг мэдээлэл нэлээд нэмэгдэж, бодлогын судалгаа хийх сонирхолтой хүмүүсийн тоо олширч байна. Бодлого боловсруулж, хэрэгжүүлдэг төрийн байгууллагууд дэргэдээ бодлогын судалгааны институт, төвүүдтэй болоод зогсохгүй их дээд сургуулиуд магистрын түвшний сургалтаар бодлогын судалгааны арга зүйг зааж эхлээд байна. 2003 онд бодлогын судалгааны арга зүйг таниулах, бодлогын үйл явцыг судалгаанд тулгуурласан хэлэлцүүлгээр баяжуулах зорилт тулгамдаж байсан бол өнөөдөр энэ нь үндсэндээ бодит биеллээ олжээ. Улмаар бодлогын судалгаа, шинжилгээний аргазүйг иргэний нийгмийн оролцооны арга хэрэгсэл болгон хөгжүүлэх зорилтыг 2012 онд шинээр дэвшүүлж тэтгэлэгт хөтөлбөрөө өөрчиллөө.

Энэ жилийн хөтөлбөрт нийт 12 төслийн санал ирснээс дараах төсөл шалгаран хэрэгжиж байна:

Дэвшүүлж буй бодлогын асуудал	Судлаач
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхэлбэл нийгмийн даатгалд хамрагдах боломж	Б.Чулуундолгор, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Б.Энхжаргал, Гүнж төв ТББ-ын нийгмийн ажилтан
Өмчлөл болон эзэмшилд байгаа газрыг төрийн болон орон нутгийн тусгай хэрэгцээнд эргүүлэн дайчлах тохиолдолд нөхөн олговор тогтоох, хэлцэл хийх, нүүлгэн шилжүүлэх үйл явцыг журамлах нь	С. Дондов, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн

## БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ АЖИЛ

ННФ бодлогын судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаагаа зөвхөн иргэний нийгмээр хязгаарлаагүй юм. 2012 онд бид нийгмийн ухааны хавсарга шинжилгээний өөрийн гэсэн уламжлал, хандлагатай энэхүү арга зүйг танилцуулах нэг өдрийн сургалтын модуль боловсруулан тэтгэлэгт хөтөлбөрт саналаа ирүүлсэн 12 ТББ-ын 40 гаруй ажилтан, Хууль зүйн

үндэсний хүрээлэнгийн 10 гаруй судлаачийг хамруулсан хоёр удаагийн сургалт хийгээд байна. 2013 онд эдгээр сургалтыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ бодлогын судалгааны тайлан бичих талаар мөн нэг өдрийн танилцуулах сургалтын модуль боловсруулж хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Энэ хүрээнд 2003 онд анх орчуулсан “Үр бүтээлтэй бодлогын баримт бичиг боловсруулах нь” гарын

авлагыг хоёрдахь удаагийн орчуулгаар дахин хэвлэхэд бэлэн болоод байна.

2012 онд Непал Улсын “Нийгмийн яриа хэлэлцүүлгийн төв” ТББ-тай туршлага солилцон бодлогын судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх, бодлогын судалгаа удирдах чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.



Бодлогын судалгааны арга зүйг танилцуулах сургалтын явц



## ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Сангуудын “Дээд боловсролыг дэмжих хөтөлбөр”-өөс Төв Европ, хуучин ЗХУ-ын улс орнууд, мөн Төв Ази болон Монголд хэрэгжүүлж буй энэхүү санаачлага нь нийгмийн ухааны дээд боловсрол олгох сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх зорилготой юм. Ингэхдээ өндөр хөгжилтэй улс орны нэр хүндтэй их сургуулийн

магистр, докторын зэрэгтэй залуу боловсон хүчнийг төрийн мэдлийн их дээд сургуулийн нийгмийн ухааны тэнхимд үндсэн мэргэжлээрээ багшлахад нь дэмжлэг үзүүлдэг болно. 2004 оноос Монголд хэрэгжиж байгаа Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрт 2012-2013 хичээлийн жилд МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн Нийгэм, соёлын антропологийн тэнхим,

Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим, ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл мэндийн сургуулийн Эпидемиологи, Биостатистикийн тэнхимийн эрдэмтэн багш нар үргэлжлүүлэн хамрагдаж байгаа бол МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн Түүхий тэнхимийн багш нар шинээр элсэн ажиллаж байна.

### 2012-2013 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЖ БАЙГАА ТЭНХИМ, БАГШ НАР

Тэтгэлэг хүртэгч	Төгссөн сургууль, зэрэг	Судалгааны чиглэл
МУИС-ийн Нийгэм, соёлын антропологийн тэнхим		
Ж. Лхагвадэмчиг	Магистр, Буддын шашин судлал, Хонг Конгийн Их сургууль	Шашны антропологи, Монгол болон Өвөр Ази судлал, хөгжлийн антропологи, хэлний антропологи
Б. Цэцэнцолмон	Магистр, угсаатны хөгжим судлал, Тайванийн Үндэсний Урлагийн Их сургууль	Үндэсний хөгжим судлал, урлагийн антропологи, ардын урлаг
Ш. Туяа	Магистр, Харьцуулсан уран зохиол судлал, АНУ-ын Висконсин мужийн Их сургууль	Улс төрийн антропологи
Зөвлөх: Дэвид Снийт, Кембрижийн Их Сургуулийн Нийгмийн антропологийн тэнхимийн эрхлэгч	PhD, Нийгмийн антропологи, Кембрижийн Их сургууль, 2006	Өвөр Азийн улс төрийн байгууламжийн түүх, нүүдлийн мал аж ахуй, газар ашиглалт болон байгаль орчин, пост-социалист нийгмийн өөрчлөлтүүд, улс төрийн соёл болон эдийн засгийн институцууд, хөгжлийн антропологи

Тэтгэлэг хүртэгч	Төгссөн сургууль, зэрэг	Судалгааны чиглэл
ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл мэндийн сургууль		
Г. Даваа	PhD, ЭМШУИС, Монгол (2011), Магистр, Нийгмийн Эрүүл мэнд, Хибру Их сургууль, Израиль (2004)	Халдварт болон халдварт бус өвчин судлал, эмнэлгийн орчин дахь халдварлалт
Д. Даваалхам	PhD, Нийгмийн Эрүүл мэнд, Жичи Эрүүл Мэндийн Их сургууль, Япон 2007	Вируст гепатит судлал, Кавасакигийн өвчин, хавдар судлал, зүрх судасны өвчин
Д. Гантуяа	MPH, Нийгмийн Эрүүл мэнд, Дебрецени Нийгмийн Эрүүл мэндийн сургууль, Унгар	Халдварт бус өвчний эпидемиологи, Эх хүүхдийн Эрүүл мэнд, Эрүүл мэндийн тусламж
Зөвлөх: Луис Анн Макнат, Олбани дахь Нью Йорк Мужийн Их Сургуулийн Нийгмийн Эрүүл мэндийн сургууль	PhD, Эпидемиологи, Аиова мужийн Их сургуулийн Анагаах ухааны коллеж	Эпидемиологи, халдварт өвчин судлал, хүчирхийллээс сэргийлэх хөтөлбөр
МУИС-ийн Эдийн засгийн тэнхим		
Ч. Нарантуяа	Магистр, экономикс, Сидней Их сургууль, Австрали	Төсөв, санхүүгийн бодлого, мөнгөний бодлого, институцууд ба төрийн бодлого
Б. Алтанцэцэг	PhD, экономикс, Виржиния мужийн Их сургууль, АНУ	Макро эдийн засгийн онол, олон улсын эдийн засаг
Б. Отгонтөгс	PhD, Боловсролын эдийн засаг, Колумбийн Их сургуулийн Багшийн Коллеж, АНУ	Боловсролын эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг
Б. Эрдэнэбат	PhD, экономикс, Манчестерийн Их сургууль, Их Британи	Хэрэглээний эконометрикс, санхүүгийн экономикс, олон улсын бизнесийн мөчлөг, инфляци, нөөц баялгийн хяслан
Б. Соёлмаа	PhD, экономикс, Манчестерийн Их сургууль, Их Британи	Макро эдийн засгийн загварчлал, эдийн засгийн өсөлт, засаглал, микро санхүү, орлого хуваарилалт ба ядуурал
С. Даваасүрэн	Ph.D., экономикс, Өмнөд Нью Хемпшир мужийн Их сургууль, АНУ	Хөгжлийн эдийн засаг, хөгжиж буй орнуудын макро эдийн засаг
З. Манлайбаатар	Магистр, эдийн засгийн бодлого, Төв Европын Их сургууль	Санхүүгийн зах зээл, глобал зах зээлийн эдийн засгийн бодлого
Зөвлөх: Шломо Вэбер, Саутен Методист Их сургууль, АНУ	PhD, экономикс, Хебру Их сургууль, Израиль	Улс төр, эдийн засгийн онол, экономикс
МУИС-ийн Түүхийн тэнхим		
Д. Баярсайхан	Ph.D, түүх, Оксфордын Их сургууль, Их Британи	Их Монгол гүрний үеийн түүх
О. Оюунжаргал	Ph.D, Бүс нутаг судлал, Токоху Их сургууль, Япон	Манжийн үеийн Монголын түүх, эх сурвалж судлал
Зөвлөх: Кристофер Атвүүд, Индиана мужийн их сургуулийн Төв Еврази судлалын тэнхимийн эрхлэгч	Ph.D., Монголын түүх, Бдүүмингтон дахь Индиана мужийн Их сургууль	Монголын эзэнт гүрний түүх, Монгол болон Өвөр монгол судлал

# “ДОРНО ДОРНО – ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ” БҮСИЙН ХӨТӨЛБӨР

1991 оноос эхлэн хэрэгжиж буй “Дорно Дорно – Хил Хязгааргүй Түншлэл” хөтөлбөр нь хуучин социалист болон Төв, Зүүн Европын орнуудаас гадна Ази, Африк, Латин Америкийн орнуудын иргэний нийгмийн байгууллагуудад мэдлэг мэдээлэл, туршлага хуваалцахад нь дэмжлэг үзүүлж байна. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санааны чухал сэдвүүд болох хүний эрх, шударга ёс, хэвлэл мэдээлэл, засаглал, нийгмийн хариуцлага, олон улсын болон геополитикийн харилцаа зэрэг асуудалд түлхүү анхаардаг.

Монголын иргэний нийгмийн төлөөлөл, нийгмийн салбарын мэргэжилтнүүд Дорно Дорно хөтөлбөрийн хүрээнд зохиогдож буй олон улсын болон бүсийн хэмжээний хурал, семинар, сургалтад оролцохын сацуу өөрийн орны туршлагаа бусад улсын иргэний нийгэм, нийгмийн идэвхитэн, төлөөлөгчдөд танилцуулж байна. 2012 онд уг хөтөлбөрийн дэмжлэгээр дараах байгууллагууд олон улсын арга хэмжээнд оролцлоо.

- Түгээмэл хөгжил төв ТББ-ын төлөөлөгчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах нөхцлийг судлах зорилгоор Япон Улсын Хёого мужийн Нишиномия хотын “Мэйнстрийм”, Осака хотын “Мүчү”, “Партнер” төвүүдийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан юм. Манай

улсад хэрэгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэх нийгмийн халамжийн үйлчилгээг тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, оролцоонд түшиглэн зөв, оновчтой хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан гэж аяллын багийнхан дүгнэлээ.

- Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн нэг мэргэжилтэн Словенийн Любляня хотноо болсон “Хэвлэл мэдээллийн өөрчлөлт, шинэчлэлтийг харьцуулах нь” бүсийн зөвлөлдөх уулзалтад оролцов. Энэхүү уулзалтаар дэлхийн хэвлэл мэдээллийн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлд тулгамдаж буй асуудлыг бүс нутгаар харьцуулан хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцжээ. Уулзалтад Монголын хэвлэл мэдээллийн өөрчлөлт, шинэчлэлд сэтгүүлчдийн гүйцэтгэж буй үүрэг оролцооны талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Хэлэлцүүлгийн үеэр ардчиллыг хөгжүүлж буй олон оронд сэтгүүлчийн мэргэжлийн үнэ цэнэ, үүрэг, хариуцлагын талаарх ойлголт дутмаг байна гэж дүгнэсэн нь сэтгүүлчдийг чадавхижуулах дараагийн алхмыг тодорхойлоход чухал ач холбогдолтой болсон гэж хөтөлбөрийн зүгээс үзэж байна.



## АНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2012 онд нийт 1,200,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 1,121,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$ 20,500 АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, \$ 42,800 Дэлхийн Банк, \$15,700 бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

#### НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</b>			
Хүний эрх	16,277	9,930	26,208
Шүүхийн хараат бус байдал	-	48,765	48,765
Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь	14,940	22,260	37,200
ТББ-уудын хөгжлийг дэмжих эрхзүйн орчин	-	13,675	13,675
Төрийн ил тод хариуцлагатай байдал, Иргэний нийгмийн оролцоо	22,217	25,567	47,784
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	17,789	-	17,789
Чөлөөт, шударга сонгууль	54,095	16,806	70,901
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</b>			
Олборлох салбарын мэдээллийн ил тод байдал	24,323	16,936	41,259
Уул уурхайн орлогыг удирдах тогтолцоог бэхжүүлэх нь	-	36,690	36,690
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	43,951	19,330	63,281
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	-	67,977	67,977
Бизнесийн орчин	-	9,953	9,953
<b>НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР</b>			
Нийгмийн үйлчилгээний хүрээмж	26,506	8,972	35,478
Боловсролын үйлчилгээний хүртээмж	50,759	7,344	58,104
Залуучуудын оролцоог дэмжих хөтөлбөр	9,150	3,426	12,576
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>			
Хөгжлийн мэдээллийн төв	-	47,308	47,308
Портал сайт	-	37,102	37,102
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	12,552	28,848	41,400
Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр	-	18,473	18,473
Дорно Дорно хөтөлбөр	11,615	219	11,834
<b>ЗАХИРГАА</b>	-	372,665	372,665
<b>НИЙТ ДҮН</b>	<b>304,174</b>	<b>812,247</b>	<b>1,116,421</b>

#### ТЭТГЭЛГИЙН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон	Хувь хүнд олгосон	Тэтгэлгийн зардал
<b>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</b>			
Хүний эрх	16,277	-	16,277
Шүүхийн хараат бус байдал	-	-	-
Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь	14,940	-	14,940
ТББ-уудын хөгжлийг дэмжих эрхзүйн орчин	-	-	-
Төрийн ил тод хариуцлагатай байдал, Иргэний нийгмийн оролцоо	13,390	8,827	22,217
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	11,699	6,090	17,789
Чөлөөт, шударга сонгууль	54,095	-	54,095
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</b>			
Олборлох салбарын мэдээллийн ил тод байдал	11,679	12,644	24,323
Уул уурхайн орлогыг удирдах тогтолцоог бэхжүүлэх нь	-	-	-
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	43,951	-	43,951
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	-	-	-
Бизнесийн орчин	-	-	-
<b>НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР</b>			
Нийгмийн үйлчилгээний хүрээмж	26,506	-	26,506
Боловсролын үйлчилгээний хүртээмж	50,759	-	50,759
Залуучуудын оролцоог дэмжих хөтөлбөр	7,658	1,492	9,150
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>			
Хөгжлийн мэдээллийн төв	-	-	-
Портал сайт	-	-	-
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	6,704	5,848	12,552
Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр	-	-	-
Дорно Дорно хөтөлбөр	8,205	3,410	11,615
<b>ЗАХИРГАА</b>	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>265,863</b>	<b>38,311</b>	<b>304,174</b>

## 2012 ОНД ОЛГОСОН НИЙТ ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ Доллар

Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэрс	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Баянхонгор	Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо	ТББ 2,768
2	Баянхонгор	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэл	ТББ 1,902
3	Говь-Алтай	Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Холбоо	ТББ 3,858
4	Дорнод	Буйр Нуур, Халх гол, Нөмрөгийн Сав Газрыг Хамгаалах Хөдөлгөөн	ТББ 3,650
5	Дорнод	Монголын Чөлөөт Нийгмийн Ажилтны Төв	ТББ 3,767
6	Дорнод	Хорол Тооно	ТББ 3,288
7	Дорнод	ХуулийнХэрэгжилтийг Хянах Иргэдийн Холбоо	ТББ 3,337
8	Дорнод	Цөмийн Цацрагийг Хянах Монголын Нийгэмлэг	ТББ 4,006
9	Дундговь	Иргэний Нийгмийн Байгууллагуудын Сүлжээ	ТББ 3,291
10	Дундговь	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо	ТББ 2,510
11	Өмнөговь	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн	ТББ 3,735
12	Төв	Иргэний Нийгмийн Сүлжээ	ТББ 2,747
13	Төв	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн	ТББ 3,073
14	Увс	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэл	ТББ 2,613
15	Ховд	Ажил Олгогчдын Бадрал Холбоо	ТББ 3,485
16	Ховд	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн	ТББ 3,325
17	Улаанбаатар	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төв	ТББ 3,586
18	Улаанбаатар	Глоб интернэшнл	ТББ 9,985
19	Улаанбаатар	Глоб интернэшнл	ТББ 9,199
20	Улаанбаатар	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	ТББ 28,100
21	Улаанбаатар	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	ТББ 16,917
22	Улаанбаатар	Гэр Бүлийн Эрүүл Мэндийн Сайн Сайхны Төлөө	ТББ 3,930
23	Улаанбаатар	Захиргааны Шинэ Санаачлага	ТББ 3,926
24	Улаанбаатар	Их Бага Баян Шарга	ТББ 3,621
25	Улаанбаатар	МИДАС	ТББ 6,825
26	Улаанбаатар	Монголын Урлагийн Зөвлөл	ТББ 2,500
27	Улаанбаатар	Монголын Худалдаа, Эд Хэрэглэгчдийн Хоршооллын Төв Холбоо	ТББ 4,139
28	Улаанбаатар	Ногоон Байгаль Ирээдүй	ТББ 4,598

Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэрс	Төрөл	Тэтгэлгийн дүн
29	Улаанбаатар	Ногоон Ертөнц Байгаль Орчин	ТББ 4,052
30	Улаанбаатар	Онол Арга	ТББ 4,032
31	Улаанбаатар	Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүдийн Клуб	ТББ 17,176
32	Улаанбаатар	Сонгогчдын Боловсрол Төв	ТББ 7,329
33	Улаанбаатар	Сууц Өмчлөгчдийн Холбоо	ТББ 3,209
34	Улаанбаатар	Татварт Иргэний Хяналт	ТББ 4,212
35	Улаанбаатар	Туул голоо хамгаалья Хөдөлгөөн	ТББ 7,132
36	Улаанбаатар	Түгээмэл Хөгжил	ТББ 8,205
37	Улаанбаатар	Түгээмэл Хөгжил	ТББ 5,228
38	Улаанбаатар	Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо	ТББ 5,848
39	Улаанбаатар	Филантропи Төв	ТББ 12,778
40	Улаанбаатар	Хатансэмбэрүү	ТББ 3,645
41	Улаанбаатар	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг Эхийн Холбоо	ТББ 5,743
42	Улаанбаатар	Хөгжлийн Хэлхээ	ТББ 3,962
43	Улаанбаатар	Хүнсний Аюулгүй Байдал, Хоол Тэжээлийн Нийгэмлэг	ТББ 4,002
44	Улаанбаатар	Хүнсний Тусгаар Байдлын Төлөө Хүмүүсийн Эвсэл	ТББ 4,097
45	Улаанбаатар	Хүүхэд Хүүхдийн Төлөө	ТББ 7,658
46	Улаанбаатар	Эмэгтэй Удирдагч Сан	ТББ 4,339
47	Улаанбаатар	Булаг Шанд Гол Мөрний Эхийг Хамгаалах Сан	ТББ 3,679
48	Улаанбаатар	С. Дондов	Баг 6,704
49	Улаанбаатар	Б. Батболд	Иргэн 2,015
50	Улаанбаатар	Г. Цэцэгдэлгэр	Иргэн 3,195
51	Улаанбаатар	Г. Чагнаадорж	Иргэн 2,615
52	Улаанбаатар	Д. Цолмон	Иргэн 746
53	Улаанбаатар	Д. Цэрэнжав	Иргэн 2,895
54	Улаанбаатар	М. Мөнхмандах	Иргэн 3,410
55	Улаанбаатар	Н. Баярсайхан	Иргэн 3,195
56	Улаанбаатар	Н. Баярсайхан	Иргэн 3,063
57	Улаанбаатар	Н. Баярсайхан	Иргэн 2,470
58	Улаанбаатар	С. Оюунтуяа	Иргэн 2,737
59	Улаанбаатар	Т. Гэрэлмаа	Иргэн 2,895
60	Улаанбаатар	Б. Нарангэрэл	Иргэн 746
61	Улаанбаатар	Ч. Туяа	Иргэн 2,481
<b>НИЙТ ДҮН</b>			<b>304,174</b>

## АЖИЛТНУУД

### Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

---

Г. Уранцоож	Удирдах зөвлөлийн дарга, Хүний Эрх-Хөгжил төвийн тэргүүн
О. Энхтуяа	Удирдах зөвлөлийн гишүүн, Nature Conservancy олон улсын байгууллагын Монгол дахь захирал
Г. Эрдэнэбат	Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн Хуулийн Сургуулийн багш
Ч. Хашчулуун	Удирдах зөвлөлийн гишүүн, Үндэсний Хөгжил -Шинэтгэлийн хорооны дарга
С. Цэрэндорж	Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний Эрх -Ардчилал судалгааны төвийн тэргүүн
Т. Ундарьяа	Удирдах зөвлөлийн гишүүн, MONFEMNET үндэсний сүлжээний зохицуулагч
Ж. Үнэнбат	Удирдах зөвлөлийн гишүүн, Компанийн Засаглалын Хөгжлийн Төв ТББ-ын гүйцэтгэх захирал

### Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал:

---

П.Эрдэнэжаргал	jargal@forum.mn
----------------	-----------------

### Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд:

---

П. Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	badmaa@forum.mn
Н. Дорждарь	Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер	dorjdari@forum.mn
Б. Мөнхсоёл	Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер	soyoloo@forum.mn
А. Гэрэлмаа	Нийгэм, Боловсролын хөтөлбөр хариуцсан менежер	gerelmaa@forum.mn
Д. Энхцэцэг	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	enkhee@forum.mn
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	fassistant@forum.mn
Д. Балжид	Мэдээллийн менежер	baljid@forum.mn
Д. Баярмаа	Мэдээллийн ажилтан	dircassist@forum.mn
Д. Гантуяа	Порталын ерөнхий редактор	gantuya@forum.mn
Д. Жавхлан	Санхүү, захиргааны захирал	javkhlan@forum.mn
Д. Аюуш	Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер	ayush@forum.mn
Д. Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	ulzii@forum.mn
Т. Отгонбаяр	Захирлын туслах	otgoo@forum.mn
Б. Баатар	Жолооч	baatar@forum.mn
Г. Цэдэвхүү	Жолооч	tsedev@forum.mn
Ц. Саруул	Жолооч	saruul@forum.mn
Ш. Ганчимэг	Захиргааны туслах ажилтан	ganaa@forum.mn

Нийтлэг И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

---